



**СЭЛЭНГЭ АЙМГИЙН САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР**

ДОТООД АУДИТЫН ТАЙЛАН

**АУДИТЫН НЭР: СЭЛЭНГЭ АЙМГИЙН БАЯНГОЛ СУМЫН ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН 2024-2025 ОНЫ ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**

Аудитын код: ДА-2026/11/-ҮА

2026 он

Агуулга	Хуудасны дугаар
Товчилсон үгийн жагсаалт	2
Хүснэгтийн товчьег	3
Аудитын зорилго хамрах хүрээ, арга зүй, стандартын талаарх мэдээлэл	4
Ерөнхий мэдээлэл	5
Аудитын үр дүн	6-23
Аудитаар илрүүлсэн асуудал	24-33
Илрүүлсэн зөрчлийн шийдвэрлэлт	33-34
Зөвлөмж	34-35
Зөрчлийн нэгтгэл	36

Товчилсон үгийн жагсаалт

Товчилсон үг	Утга
ДА	Дотоод аудит
БГ ТТЗ	Баянгол сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ХШҮ	Хяналт-шинжилгээ, үнэлгээ
ХЖТ	Хөгжлийн жилийн төлөвлөгөө
МУЗГҮАХ	Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр
МУЗГ	Монгол Улсын Засгийн газар
НДД	Нийгмийн даатгалын даатгал (тайланд энэ хэлбэрээр ашигласан)
УУ	Уул уурхай
ЭМГ	Эрүүл мэндийн газар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ОАТ	Орлогын албан татвар
ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ХХС	Хоршоо хөгжүүлэх сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхий захирагч
ХО	Хөрөнгө оруулалт
МТТАТ	Малын тоо толгойн албан татвар
ТБОНХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УСННББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт

Хүснэгтийн товъёг

Дугаар	Нэр
Хүснэгт 1	Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журмын үнэлгээ
Хүснэгт 2	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ
Хүснэгт 3	Бодлогын баримт бичгийн "Үр дүнгүй" арга хэмжээ
Хүснэгт 4	Хөгжлийн жилийн төлөвлөгөөний шинжилгээ
Хүснэгт 5	МУЗГҮАХ 2024-2028 — Дэд хөтөлбөрийн шинжилгээ
Хүснэгт 6	Үр дүнгүй үнэлгээний нэгтгэл
Хүснэгт 7	ХЖТ-т тусгагдсан хамааралгүй арга хэмжээний жагсаалт
Хүснэгт 8	Гүйцэтгэл хангалтгүй, санхүүжилт дутагдсанаас болж зогссон арга хэмжээнүүд
Хүснэгт 9	Дотоод хяналтын үйл ажиллагааг үнэлсэн жагсаалт /2024-2025 он/
Хүснэгт 10	Орлогын харьцуулалт
Хүснэгт 11	Орлогын төлөвлөлтийн гол алдаанууд
Хүснэгт 12	2025 оны зарлагын харьцуулалт
Хүснэгт 13	Зарлагын төлөвлөлтийн гол асуудлууд
Хүснэгт 14	Авлага, өглөгийн бүртгэл
Хүснэгт 15	2024 оны санхүүжилтийн эх үүсвэрийн задаргаа
Хүснэгт 16	2025 оны санхүүжилтийн эх үүсвэрийн задаргаа
Хүснэгт 17	Гэрээний хэрэгжилт
Хүснэгт 18	ОНХС-ийн санхүүжилт
Хүснэгт 19	Өмнөх оноос шилжсэн төсөл арга хэмжээ /2024 он/
Хүснэгт 20	Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ /2024 он/
Хүснэгт 21	ОНХС-ийн МТТАТ -аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ 2024 он
Хүснэгт 22	Өмнөх оноос шилжсэн төсөл арга хэмжээ /2025 он/
Хүснэгт 23	Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ /2025 он/
Хүснэгт 24	ОНХС-ийн МТТАТ -аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ 2025 он
Хүснэгт 25	Хоршоог хөгжүүлэх сангийн санхүүжилт
Хүснэгт 26	Хувийн хэргийн бүрдүүлэлт
Хүснэгт 27	Зээлийн авлагын харьцуулалт
Хүснэгт 28	Зээлийн олголтын харьцуулалт
Хүснэгт 29	Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт
Хүснэгт 30	Зээлийн шалгуур

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ СТАНДАРТЫН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ	
Аудит хийх үндэслэл, бүрэн эрх:	Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйл, 14.2.10, 69 дүгээр зүйлийн 69.1, Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 8 дугаар зүйлийн 8.1.1, "Дүрэм батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Дотоод аудитын дүрэм", Дотоод аудитын хорооны 2026 оны 1 дүгээр тогтоолоор батлагдсан Дотоод аудитын 2026 оны төлөвлөгөө, хуваарийг тус тус үндэслэн дотоод аудитыг хийж гүйцэтгэнэ.
Аудитын зорилт:	Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Төсвийн төвлөрүүлэн захирагч (цаашид БГ ТТЗ гэх)-ийн үйл ажиллагаа нь төрийн үйлчилгээний чанар, хууль тогтоомжийн хэрэгжилт болон төсвийн үр ашигтай явагдаж байгаа эсэхийг магадлан шалгаж, эрсдэлийг илрүүлэх замаар удирдлагыг бодит мэдээллээр хангахад оршино.
Аудитын хамарсан хүрээ:	Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024-2025 оны үйл ажиллагааг хамруулав.
Аудитын арга зүй:	Аудитыг Дотоод аудитын дэлхийн стандартууд болон Сангийн сайдын 2019 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 268 дугаар тушаалаар баталсан Улсын салбарын дотоод аудитын аргачлалын дагуу аудитын зорилго, зорилт, ярилцлага, түүвэр шалгалт, харьцуулалт, статистик мэдээллийн дүн шинжилгээ, бодлогын хэрэгжилтийн үнэлгээ зэрэг арга зүйг ашиглан хийж гүйцэтгэв.
Аудитын шалгуур, үзүүлэлт:	<ul style="list-style-type: none"> • Аудитад асуудлын шинжилгээний асуултын дагуу нарийвчлан боловсруулсан аудитын арга зүй, хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой дараах хууль, эрх зүйн актын холбогдох заалтыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа.Үүнд: • Авлигын эсрэг хууль • Иргэний хууль • Ашигт малтмалын тухай хууль • Төрийн албаны тухай хууль • Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль • Төсвийн тухай хууль • Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль • Хөдөлмөрийн тухай хууль • Төрийн хэмнэлтийн тухай хууль • Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль • Татварын ерөнхий хууль • Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам • Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам • Хоршоо хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам • УСННББОУС болон бусад стандартууд • Байгууллагын хөдөлмөрийн дотоод журам • Байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг • Бусад хууль, эрх зүйн актууд
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа:	Санхүүгийн хяналт, дотоод аудитын газрын дотоод аудитор Г.Дорждэрэм 2026 оны 04 дугаар сарын 27-ний өдрөөс 2026 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

1. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Засаг даргын эрх зүйн байдал

Монгол Улсын Үндсэн хуулийн 60 дугаар зүйлд аймаг, сумын нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг Засаг дарга хэрэгжүүлэхээр, 61 дүгээр зүйлд Засаг дарга нь тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ төрийн төлөөлөгчийн хувьд хууль тогтоомж, Засгийн газар болон харьяалах дээд шатны байгууллагын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллахаар тус тус заасан байна.

Сумын Засаг даргын үндсэн чиг үүрэг

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 56.1-д "Засаг дарга нь харьяалах нутаг дэвсгэртээ хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, харьяалах дээд шатны Засаг даргын шийдвэрийн гүйцэтгэлийг хангах, тухайн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий төрийн төлөөлөгч мөн" гэж заасан байна.

Мөн тус хуулийн 59.1-д сумын Засаг дарга дараах бүрэн эрхийг хэрэгжүүлэхээр тогтоосон байна. Үүнд:

- Хууль тогтоомж, Засгийн газар болон дээд шатны Засаг даргын шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх;
- Сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийн төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- Сумын төсөв боловсруулах, батлуулах, гүйцэтгэлийг зохион байгуулах;
- Төсвийн ерөнхийлөн захирагчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх;
- Орон нутгийн өмчийн ашиглалт, хамгаалалтыг зохион байгуулах;
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэв журмыг хангах;
- Хүнсний аюулгүй байдал, мал аж ахуй, мал эмнэлгийн үйл ажиллагааг зохион байгуулах;
- Газрын ашиглалт, байгаль орчны хамгаалалтыг хангах;
- Татварын орлогыг төвлөрүүлэх ажлыг зохион байгуулах;
- Боловсрол, соёл, эрүүл мэнд, спортын байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавих;
- Гамшиг, аюулт үзэгдлийн үед шуурхай арга хэмжээ авч ажиллах;
- Засаг даргын орлогч болон Тамгын газрын даргыг томилох, чөлөөлөх зэрэг бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

1.1 Ерөнхий мэдээлэл

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Засаг дарга нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид заасан бүрэн эрхийн хүрээнд төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, сумын эдийн засаг, нийгмийн хөгжлийг удирдан зохион байгуулах, төсөв санхүү, орон нутгийн өмч, газар ашиглалт, байгаль орчин, гамшгаас хамгаалах, нийгмийн хэв журам сахиулах, төрийн үйлчилгээний хүртээмжийг хангах чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тус сумын Засаг даргын албан тушаалыг 2020 оны 11 дүгээр сараас 2024 оны 12 дугаар сар хүртэл Р.Батжаргал, 2024 оны 12 дугаар сараас 2025 оны 10 дугаар сар хүртэл Б.Болор-Эрдэнэ, 2025 оны 10 дугаар сараас өнөөдрийг хүртэл Н.Давааням нар тус тус эрхэлж байна.

1.2 Засаглал, хариуцлагын тогтолцоо

Засаг дарга нь тухайн нутаг дэвсгэрт төрийн удирдлагыг хэрэгжүүлэгч бөгөөд Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын өмнө ажлаа тайлагнаж, хууль тогтоомж, Засгийн газар, аймгийн Засаг даргын шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй. Мөн өөрийн бүрэн эрхийн хүрээнд захирамж гаргаж, төрийн байгууллага, иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагааг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулах бүрэн эрхтэй.

2. АУДИТЫН ҮР ДҮН

2.1 Засаглал, дотоод хяналт ба эрсдэлийн удирдлага

Хүснэгт 1 Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журмын үнэлгээ

Үнэлгээний ангилал	Биелэлтийн хувь	Утга
Үр дүнтэй	85–100%	Зорилтот түвшний 85 буюу түүнээс дээш хувийг биелүүлсэн
Үр дүн хүлээгдэж байгаа	60–84%	Зорилтот түвшний 60–84 хувийг биелүүлсэн
Үр дүн хангалтгүй	30–59%	Зорилтот түвшний 30–59 хувийг биелүүлсэн
Үр дүн гараагүй	0–29%	Зорилтот түвшний 29 хувь буюу түүнээс доош биелүүлсэн

Эх сурвалж: МУ-ын ЗГ-ийн 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.5-ын 1 дэх хэсэг

Аймгийн ЗДТГ-ын ХШҮ хэлтсийн үнэлгээгээр Баянгол сумын бодлогын баримт бичгийн хэрэгжилт 2024 онд 84.03%, 2025 онд 69.43% — өмнөх оноос 14.6 хувиар буурсан байна.

Аудитаар:

- 2025 оны ХЖТ — Нийт 151 үнэлэгдсэн арга хэмжээ,
- МУЗГҮАХ 2024-2028 — Нийт 283 үнэлэгдсэн арга хэмжээ

Хүснэгт 2 Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ

Үнэлгээний ангилал	2025 оны ХЖТ (151)	МУЗГҮАХ 2024-2028 (283)	Нийт (434)
<input checked="" type="checkbox"/> Үр дүнтэй (85–100%)	66 (43.7%)	115 (40.6%)	181 (41.7%)
<input type="checkbox"/> Үр дүн хүлээгдэж байгаа (60–84%)	22 (14.6%)	47 (16.6%)	69 (15.9%)
<input type="checkbox"/> Үр дүн хангалтгүй (30–59%)	9 (6.0%)	44 (15.5%)	53 (12.2%)
<input type="checkbox"/> Үр дүн гараагүй (0–29%)	54 (35.8%)	77 (27.2%)	131 (30.2%)
Нийт үр дүнгүй (85%-аас доош)	85 (56.3%)	168 (59.4%)	253 (58.3%)

Хүснэгт 3 Бодлогын баримт бичгийн "Үр дүнгүй" арга хэмжээ

Үзүүлэлт	ХЖТ - 2025	МУЗГҮАХ (2024-2028)	Нийт
Нийт "Үр дүнгүй" арга хэмжээ (<85%)	85	168	253
Үүнээс: 0% (Огт хэрэгжээгүй)	17	69	86

Үүнээс: 1% – 49% (Маш хангалтгүй)	46	52	98
Үүнээс: 60% – 84% ("үр дүн хүлээгдэж байгаа")	22	47	69

Хүснэгт 4 Хөгжлийн жилийн төлөвлөгөөний шинжилгээ

Дэд хөтөлбөр	Нийт (85<)	Үр дүн гараагүй (0-29%)	Үр дүн хангалтгүй (30-59%)	Үр дүн хүлээгдэж (60-84%)	Дундаж
2.2. Соёл, урлаг, өв заншил	6	5	0	1	11.8%
2.3. Эрүүл мэнд	18	18	0	0	0.7%
2.4. Биеийн тамир	8	8	0	0	0.9%
2.5. Хүүхэд, залуучууд, гэр бүл	4	0	0	4	70.0%
2.6. Хөдөлмөр эрхлэлт, НДД	6	0	2	4	63.3%
3.3. Хүнс, хөдөө аж ахуй	7	2	0	5	50.0%
3.4. Байгаль орчин, УУ, ногоон	4	1	2	1	42.5%
3.6. Төсөв, санхүүгийн бодлого	6	6	0	0	0.9%
4.1. Цахим засаглал	13	11	2	0	8.1%
4.3. Хүний эрх, авлигагүй засаглал	2	0	1	1	60.0%
4.4. Хууль сахиулах байгууллага	1	0	0	1	70.0%
4.5. Батлан хамгаалах	1	1	0	0	1.0%
Боловсрол (нийт)	7	0	2	5	64.3%

Хүснэгт 5. МУЗГҮАХ 2024-2028 — Дэд хөтөлбөрийн шинжилгээ

Дэд хөтөлбөр	Нийт (85<)	Үр дүн гараагүй (0-29%)	Үр дүн хангалтгүй (30-59%)	Үр дүн хүлээгдэж (60-84%)	Дундаж
2.2.1. Тэгш, хүртээмжтэй боловсрол	46	28	8	10	23.0%
3.3.4. ХАА — Хоршоо, Чинээлэг мал	17	3	9	5	42.4%
2.1.1. Гэр бүл, хүн амын бодлого	12	4	3	5	41.7%
3.4.2. Уур амьсгалын өөрчлөлт	11	5	6	0	21.8%
2.2.4. Цахимжсан боловсрол	10	4	1	5	40.0%
2.2.2. Мэдлэг чадвартай мэргэжилтэн	8	5	0	3	26.2%
3.4.1. Биологийн олон янз байдал	8	7	0	1	8.8%
2.2.3. Багшлах хүний нөөц	6	2	3	1	30.0%
3.4.3. Ногоон эдийн засаг	5	4	1	0	10.0%
2.1.2. Хөдөлмөр эрхлэлт	4	2	1	1	30.0%
2.1.3. Нийгмийн баталгаа	3	0	2	1	50.0%
4.2.3. Төрийн албаны реформ	2	2	0	0	0.0%
4.3.1. Цахим засаглал / E-Mongolia	2	0	1	1	60.0%
4.4.1. Үндэсний эв нэгдэл	2	0	1	1	60.0%
2.3.2. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ	1	1	0	0	0.0%
2.3.3. Эм, эмнэлгийн хэрэгсэл	1	1	0	0	0.0%
4.2.4. Орон нутгийн засаглал	1	1	0	0	0.0%

МУ-ын ЗГ-ийн 2025 оны 43 дугаар тогтоолоор батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.5-ын 1 дэх хэсэгт тогтоосон 4 ангиллын дагуу Баянгол сумын ЗДТГ-ийн 2025 оны хөтөлбөрийн биелэлтэд дараах байдалтай байна:

Хүснэгт 6. Үр дүнгүй үнэлгээний нэгтгэл

Тайлан	Нийт	Үр дүнтэй (85%+)	Үр дүн хүлээгдэж (60-84%)	Үр дүн хангалтгүй (30-59%)	Үр дүн гараагүй (0-29%)
2025 оны ХЖТ	151	66 (43.7%)	22 (14.6%)	9 (6.0%)	54 (35.8%)
МУЗГҮАХ 2024-2028	283	115 (40.6%)	47 (16.6%)	44 (15.5%)	77 (27.2%)
НИЙТ	434	181 (41.7%)	69 (15.9%)	53 (12.2%)	131 (30.2%)

Нийт 434 арга хэмжээний 58.3% (253) зорилтот түвшинд хүрээгүй бөгөөд 30.2% (131) нь "үр дүн гараагүй" ангилалд орсон нь онцгой анхаарал шаардаж байна.

Хүснэгт 7.ЖТ-т тусгагдсан хамааралгүй арга хэмжээний жагсаалт

Мөр(үүд)	Үйл ажиллагаа	Хүрсэн талбарт бичсэн	Хувь	Асуудал / Хэрэгтэй тайлбар
Мөр 8-13 (6 мөр)	Бүсийн хөгжлийн 2040 төлөвлөгөө боловсруулах гэх мэт	Хамааралгүй		Алтанбулаг, бүсчилсэн хөгжлийн 6 ажил — ямар шалтгаанаар хамааралгүй болохыг тайлбарлаагүй
Мөр 14-17 (4 мөр)	Алтанбулаг чөлөөт бүсийн дэд бүтцийн ажлууд	Хамааралгүй		4 их дэд бүтцийн ажил — Сүхбаатар/аймгийн хэмжээний ажлыг яагаад Баянгол суманд тавьсан шалтгаан тайлбарлаагүй
Мөр 18-22 (5 мөр)	47.5 км авто зам, Амарбаясгалант хийд зам, Орхонтуул-Цээл зам	Хамааралгүй		Улсын чанартай авто замын ажлуудыг суманд тавьсан. 'Хамааралгүй' гэсэн ч тайлбар байхгүй
Мөр 79	"Чингисийн бага нас" дуулалт жүжиг	хамааралгүй	0%	Яагаад хамааралгүй болох тайлбаргүй. Мөн 0% гүйцэтгэл — зөрчилтэй
Мөр 100	Телемедицин 6 байгууллагад нэвтрүүлэх	Аймаг, сумын ЗДТГ, ЭМГ	0%	Хүрсэн талбарт байгууллагын нэр бичсэн. Тайлбар утгагүй. 0% — яагаад?
Мөр 101	Эрүүл мэндийн байгууллагын хүчин чадал нэмэгдүүлэх	хамааралгүй	0%	Зорилт тодорхойгүй. 'Хамааралгүй' гэхэд ямар агуулгатай болохыг тайлбарлаагүй
Мөр 109	"Чадварлаг эмч" хөтөлбөр хэрэгжүүлэх	Хамааралгүй	0%	Зорилт = 0 байхад 0% тооцсон нь учиргүй. 'Хамааралгүй' гэхэд яагаад тавьсан?

Мөр 279-281 (3 мөр)	Ухаалаг цэг, цахим хуудсаар өргөдөл авах, улсын бүртгэлийн программ	Хамааралгүй	0%	Цахим үйлчилгээний 3 зорилт — аймгийн/улсын шийдвэрлэх ажлыг тайлбаргүйгээр 'хамааралгүй' гэсэн
---------------------	---	-------------	----	---

Хүснэгт 8. Гүйцэтгэл хангалтгүй, санхүүжилт дутагдсанаас болж зогссон арга хэмжээнүүд

Эх сурвалж / Мөр	Арга хэмжээ	Гүйцэтгэл	Санхүүжилтийн асуудлын баримт	Гол асуудал
ХЖТ Мөр 45	"Өдөр бүр нэг аяга сүү"	70%	"...хөтөлбөрийн хэрэгжүүлэх санхүүжилт улсын төсвөөс тавигдаагүй байгаа хэдий ч сургуулийн эцэг эхийн дэмжлэгтэйгээр хэрэгжүүлсэн." — Улсын санхүүжилт байхгүй тул 70%-д зогссон.	Улсын төсвөөс санхүүжилт тавигдаагүй
ХЖТ Мөр 56	Сургалтын байгууллагын тоног төхөөрөмж-2	70%	Аймгийн Засаг дарга хандиваар Багшийн хөгжил танхим – 50,000.0 мянган төгрөг, Хоол үйлдвэрлэл – 30,985.0 мянган төгрөг. Төсвийн хөрөнгө байхгүй тул хандиваар хэрэгжүүлсэн.	Хандив дээр тулгуурласан — тогтвортой биш
ХЖТ Мөр 209	Механикжсан зоорийн ажил	70%	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа — гэтэл суурин цутгалт хийхэд л зогссон. Санхүүжилтийн хязгаарлалтаас болж дуусгаж чадаагүй.	Улсын хөрөнгөд хамааралтай, дуусаагүй
ХЖТ 158 мөр	ХЖТ санхүүжилт хоосон	—	297 арга хэмжээний 158 (53.2%)-д санхүүжилтийн дүн оруулаагүй. Санхүүжилт тодорхойгүй бол ажлын хэрэгжих эсэхийг урьдчилан мэдэх боломжгүй.	53.2% = санхүүжилт тодорхойгүй
МУЗГҮАХ 2.1.1	Гэр бүлийн бодлого зорилтууд	27.7%	18 зорилтоос 7 нь хагас жилд 0%. Гэр бүлийн дэмжлэгийн ихэнх хөтөлбөр улсын төсвийн санхүүжилтэд суурилдаг. Орон нутгийн бюджет дангаараа шийдвэрлэх боломжгүй.	Улсын санхүүжилттэй холбоотой, орон нутаг хянах боломжгүй
МУЗГҮАХ 3.4	Байгаль орчны 25 зорилт	12%→17%	Ногоон хөгжлийн зорилтуудын хэрэгжилтэд хангалттай санхүүжилт байгаагүй. Орон нутгийн засаг захиргааны чадавх болон санхүүжилт хоёулаа дутмаг.	Санхүүжилт болон чадавх хамт дутмаг
ХЖТ Мөр 82	Номын сангийн тоног төхөөрөмж	90%	Улс, аймаг, сумын аваргуудын хандиваар 1,170.0 мянган төгрөгийн тоног хийлгэсэн. Байгалийн нөөц биш, хандив шаардсан.	Байнгын санхүүжилтгүй — хандиваас хамааралтай

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн дотоод хяналтын үр нөлөө

2024-2025 онд Баянгол сумын дотоод хяналтын давтамж нэмэгдсэн байна. Доорх хүснэгтэд хоёр оны нийт үнэлгээг харуулав:

Хүснэгт 9. Дотоод хяналтын үйл ажиллагааг үнэлсэн жагсаалт /2024-2025 он/

Үнэлгээний бүрэлдэхүүн	2024 он	2025 он
Бичиг баримтын бүрэлдэхүүн	Дунд (3 баримт)	Өндөр (7 баримт)
Шалгалтын цар хүрээ	Хязгаарлагдмал (3 чиглэл)	Өргөн (5+ чиглэл)
Санхүүгийн хяналт	Үндсэн	Нарийвчлалтай (НДШ)
Эрсдэлийн тогтолцоо	Байхгүй	22 эрсдэлийн матриц
Ёс зүйн хяналт	Байхгүй	7 арга хэмжээ + тайлан

2024 онд 1 удаа байсан шалгалт 2025 онд улирал бүр болсноор тасралтгүй хяналтын зарчим хэрэгжжээ.

Өмнөх хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгасан байдал

Аймгийн Төрийн аудитын газраас хийсэн 2024 оны аудитаар: зориулалт бусаар 34,539.8 мянган төгрөг зарцуулсан; төсвийн ангилал хооронд 12,874.5 мянган төгрөг шилжүүлсэн; НДШ, ХХОАТ буруу тооцсон; шууд худалдан авалтыг хууль зөрчин зохион байгуулсан; хөрөнгийн бүртгэл болон анхан шатны баримт дутуу зэрэг зөрчил илэрсэн байна.

Өгсөн 20 зөвлөмжийн дундаж хэрэгжилт 92.5% — 18 нь бүрэн, 1 нь 50%, 1 нь хэрэгжээгүй байна.

2.2 Төсөв, санхүүгийн үйл ажиллагаа

ИТХ-ын 110, 34 дугаар тогтоолоор орлогын төлөвлөгөөг баталсан бөгөөд 2024 онд 1,946,627.0 мянган төгрөг төлөвлөснөөс 2,746,860.0 мянган төгрөг буюу 141.1%-иар, 2025 онд 2,568,133.0 мянган төгрөг төлөвлөснөөс 3,005,708.0 мянган төгрөг буюу 117.0%-иар тус тус биелүүлсэн байна.

Хүснэгт 10. Орлогын харьцуулалт

Орлогын нэр	2024 төсөв (мянган төгрөг)	2024 гүйцэтгэл	Биелэлт	2025 төсөв (мянган төгрөг)	2025 гүйцэтгэл	Биелэлт	Тайлбар
НИЙТ ОРЛОГО	1,946,627	2,746,860	141.1%	2,563,133	3,001,895	117.1%	
Татварын орлого нийт	1,581,627	2,251,162	142.3%	2,096,233	2,546,516	121.5%	–
ХХОАТ (цалин)	1,016,377	1,443,115	142.0%	1,367,234	1,837,347	134.4%	–
Үйл ажиллагааны ОАТ	150,000	299,328	199.6%	126,952	38,428	30.3%	⚠ Хэлбэлзэлтэй

Хөрөнгийн орлого (хүү)	5,000	48,482	969.6%	275,700	147,243	53.4%	△ Хэлбэлзэлтэй
Хөрөнгө борлуулсны ОАТ	15,000	18,342	122.3%	18,240	28,411	155.8%	—
Үл хөдлөх хөрөнгийн татвар	60,000	108,969	181.6%	90,839	125,676	138.4%	—
Малын татвар	239,912	130,558	54.4%	100,000	111,457	111.5%	—
Газрын төлбөр	120,000	215,626	179.7%	156,964	305,039	194.3%	—
Газрын дуудлага худалдаа	53,252	60,179	113.0%	50,000	51,226	102.5%	—
Хог хаягдлын хураамж	12,000	13,919	116.0%	40,000	33,843	84.6%	△ Хэлбэлзэлтэй
Хүү, торгуулийн орлого	335,000	463,041	138.2%	435,500	382,182	87.8%	△ Хэлбэлзэлтэй
Татварын бус орлого нийт	365,000	495,697	135.8%	466,900	455,378	97.5%	—

Хүснэгт 11. Орлогын төлөвлөлтийн гол алдаанууд

● Хөрөнгийн орлого (хүү, ноогдол ашиг) — системийн алдаа 2 жил дараалан

2024 онд 5,000 мянган төгрөг төлөвлөсөн бол 48,500 мянган төгрөг гүйцэтгэлтэй (+870%). 2025 онд харин 275,700 мянган төгрөг хэт өндрөөр төлөвлөж 147,200 мянган төгрөг-г гүйцэтгэлтэй (53.4%). Жилийн уналтын дунжийг харгалзахгүй, нэг жилийн гадаад хүчин зүйлийн нөлөөлөлд суурилсан ирээдүйн өгөөжийг алдаатай тооцоолсон.

● Үйл ажиллагааны орлогын албан татвар — 2025 онд 70%-ийн алдаа

2025 онд 127,000 мянган төгрөг төлөвлөсөн бол 38,400 мянган төгрөг-г гүйцэтгэлтэй (30.3%). 2024 онд уул уурхайн компаниудын хуримтлагдсан өрийн нэг удаагийн барагдуулалтаас үүдэж 199.6% биелэлттэй гарсан. Энэ нэг удаагийн орлогыг дараа жилийн суурь болгон ашигласан нь 2025 оны 90,000.0 гаруй мянган төгрөг дутуу төвлөрүүлсэн мэт харагдаж байна.

● Хог хаягдлын хураамж — 4 дахин нэмэгдүүлсэн үндэслэлгүй өсөлт

2024 онд 12,000 мянган төгрөг байсан хог хаягдлын хураамжийг 2025 онд 40,000 мянган төгрөг болгон 3.3 дахин нэмэгдүүлж тогтоосон ч гүйцэтгэл 33,800 мянган төгрөг (84.6%). Хэдэн ААНБ шинээр хамрагдах, одоогийн гүйцэтгэлийн хувь хэд вэ гэх суурь тооцоо хийгдээгүй байна.

● Хүү, торгуулийн орлого — 2025 онд хэт өндөр тогтоосон

2024-ийн 463,000 мянган төгрөг-ийн гүйцэтгэлд суурилж 2025-д 435,500 мянган төгрөг төлөвлөсөн ч замын хөдөлгөөний хуулийн өөрчлөлтөөс 382,200 мянган төгрөг болсон (87.8%). Бодлогын орчны өөрчлөлтийг харгалзан тооцоогүй.

● Газрын төлбөр — хамгийн зөв тооцоолох боломжтой орлого

2024 онд: 179.7%, 2025 онд: 194.3% биелэлттэй боловч энэ нь газрын дуудлага худалдааны динамик өсөлт, уул уурхайн компаниудын өр барагдуулалтаас шалтгаалсан бодит хүчин зүйл бөгөөд тогтмол суурийг хангалтгүй тооцоолсон.

● Малын татвар — өмнөх жилийн мал тооллогын дүнг үндэслээгүй

"Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн татварын алба тооцож, төлбөл зохих албан татварыг ноогдуулаагүй байна.

Мал тутамд ноогдуулах албан татварын хэмжээг 2024 онд сумын ИТХ-ын 2024 оны 97 дугаар тогтоолоор 400.0 төгрөгөөр, 2025 оны 08 дугаар тогтоолоор 1,000.0 төгрөгөөр тооцохоор тус тус шийдвэрлэсэн боловч уг тогтоолуудыг хэрэгжүүлээгүй, 97 дугаар тогтоолыг захиргааны хэм хэмжээний эмхэтгэлд нийтлүүлээгүй байна.

Иймд 2024-2025 онд мал тутамд ноогдуулах албан татварын хэмжээг тооцохдоо сумын ИТХ-ын 2021 оны 25 дугаар тогтоол (2,000.0 мянган төгрөг)-г мөрдөх нь зүйтэй байсан. Гэтэл

2024 он

- Батлагдсан төлөвлөгөө: **309,000 мянган төгрөг**
- Гүйцэтгэл: **130,600 мянган төгрөг**
- Төлөвлөгөөний биелэлт: **42.3%**
- Төлөвлөгөөнөөс дутуу: **178,400 мянган төгрөг**
- Ногдуулбал зохих татвар: **360,600 мянган төгрөг**
- Ногдуулсан татвараас төвлөрүүлж чадаагүй үлдэгдэл: **230,100 мянган төгрөг**

2025 он

- Батлагдсан төлөвлөгөө: **100,000 мянган төгрөг**
- Гүйцэтгэл: **111,500 мянган төгрөг**
- Төлөвлөгөөний биелэлт: **111.5%**
- Төлөвлөгөөг **11,500 мянган төгрөгөөр давуулан биелүүлсэн**
- Гэвч ногдуулбал зохих татвар **322,900 мянган төгрөг** байхад төвлөрүүлсэн орлого **111,500 мянган төгрөг** байгаа нь **211,400 мянган төгрөгийн татварын авлага, төвлөрүүлээгүй орлого** үлдсэн байна. Үүнээс харахад:

1. Татварын төлөвлөлт бодит ногдуулалттай уялдаагүй байна.
2. 2024 онд 42.3% биелэлт — орлого бүрдүүлэлт хангалтгүй хэрэгжсэн.
3. 2025 онд төлөвлөгөө 111.5% биелсэн боловч батлагдсан дүн ногдуулах боломжтой татварын 1/3-ийг л тусгасан байна.
4. Ногдуулсан татварын үлэмж хэмжээний авлага (2024 онд 230,100 мянган төгрөг, 2025 оны хагас жилийн байдлаар 211,400 мянган төгрөг) үүссэн нь татварын өр барагдуулах, хяналт тавих, орлого төвлөрүүлэх үйл ажиллагаа үр дүнгүй байгааг харуулж байна.
5. Малын тоо 2023 оны эцэст **132.0 мянга** байсан бол 2024 оны эцэст **161.4 мянга** болж **22.3 хувиар өссөн** хэдий ч татварын орлогыг үнэн зөв ноогдуулаагүй, бүрэн төвлөрөөгүй байна.

2024 онд нийт орлого 141.1% биелсэн боловч малын татвар 54.4%, байгалийн нөөцийн төлбөр 50.0%-д хүрсэн байна.

2025 онд нийт орлого 117.1% биелсэн боловч татварын бус орлого 97.5%, торгуулийн орлого 87.8%, хог хаягдлын хураамж 84.6%, түгээмэл тархацтай ашигт малтмалын төлбөр 33.2% биелж — зарим эх үүсвэрийн төлөвлөлт бодит нөхцөлтэй нийцээгүйг харуулав.

Хүснэгт 12. 2025 оны зарлагын харьцуулалт

Зарлагын нэр	2025 төсөв (мянган төгрөг)	2025 гүйцэтгэл (мянган төгрөг)	Биелэлт %	Үнэлгээ
НИЙТ ЗАРЛАГА (2025)	5,524,330	4,039,985	73.1%	○ Анхаарал
Цалин хөлс	1,395,739	1,230,609	88.2%	—
НД шимтгэл	174,467	112,356	64.4%	○ Анхаарал
Байр ашиглалт (түлш, цахилгаан)	608,197	579,217	95.2%	—
Хангамж, бараа материал	63,142	51,549	81.6%	—
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил	188,455	69,126	36.7%	○ Анхаарал
Урсгал шилжүүлэг	81,180	78,380	96.6%	—
Хөрөнгийн зардал нийт	2,459,218	1,668,408	67.8%	○ Анхаарал
- Барилга байгууламж	2,053,257	1,235,966	60.2%	○ Анхаарал
- Их засвар	124,461	120,143	96.5%	—
- Тоног төхөөрөмж	124,500	206,648	165.9%	● Хэт давсан
- Бусад хөрөнгө	157,000	105,650	67.3%	—
Эргэж төлөгдөх зээл	196,700	40,000	20.3%	—

Хүснэгт 13. Зарлагын төлөвлөлтийн гол асуудлууд

● Тоног төхөөрөмжийн зардал — ЭЗАнгиллын зөрчил: 157,808.2 мянган төгрөг буруу ангиллаар зарцуулагдсан

2025 онд 124,500 мянган төгрөг батлагдсан тоног төхөөрөмжийн зардалд 206,600 мянган төгрөг зарцуулагдсан. ОНХС-аас нийт 187,148.2 мянган төгрөг, аймгийн ЗДТГ-ын хөрөнгөөр 19,500.0 мянган төгрөг нийт 206,648.2 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна. Аудитаар уг зардлын дэлгэрэнгүй бүрэлдэхүүнийг шалгахад дараах байдал тогтоогдлоо: хот тээврийн машины үнэд 29,340.0 мянган төгрөг, Киоск машины үнэд 19,500.0 мянган төгрөгийг зарцуулсан нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалын хавсралтад заасан 222001 "Тоног төхөөрөмж" ангилалд зөв хамаарна. Харин хатуу хучилттай замын санхүүжилт 118,135.0 мянган төгрөг, цамхагт гэрэлтүүлгийн ажил 14,673.2 мянган төгрөг, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх 20,000.0 мянган төгрөг, цахим худаг байгуулах 5,000.0 мянган төгрөг, нийт 157,808.2 мянган төгрөг нь барилга байгууламжийн шинж чанартай ажил, үйлчилгээ тул 220001 "Барилга байгууламж" ангилалд хамаарах байтал 222001 "Тоног төхөөрөмж" ангилалаар буруу гаргасан байна. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын 220001, 222001 дугаарт заасан ангиллыг зөрчсөн болно.

● Барилга байгууламж— 60.2% л биелэлттэй, 817,000 мянган төгрөг зарцуулагдаагүй

2025 онд 2,050,000.0 мянган төгрөг батлагдсан барилгын зарлагаас 1,240,000 мянган төгрөг--г зарцуулсан. Улсын хэмжээний санхүүгийн хүндрэл, тендер саатал, Хэмнэлтийн хуулийн хязгаарлалтыг гол шалтгааны нэгж тодруулгад тайлбарласан нь үндэслэлтэй ч, он дамжих ажлын тоо нэмэгдэж байгаа нь (2024: 3, 2025: 4) санхүүгийн сахилга бат муу байна.

● НД шимтгэлийн гүйцэтгэл цалингаас хол зөрж байна

Цалин хөлс 88.2% биелэлттэй байхад НД шимтгэл 64.4%-д хүрсэн. Цалинтай шууд пропорциональ байх ёстой НД шимтгэл нь ойролцоо 88-89% байх ёстой. 23.8%-ийн зөрүү нь НД шимтгэлийн хойшлолт, эсвэл гэрээт ажилтнуудын шимтгэлийн бүртгэлтэй холбоотой

Хүснэгт 14. Авлага, өглөгийн бүртгэл

/мян.төг/

Үзүүлэлт	Өмнөх он	Нэмэгдсэн	Хорогдсон	Тайлант он
Авлага	250,500.0	112,600.0	177,600.0	185,491.6
Өглөг	128,900.0	1,940,400.0	1,600,300.0	468,991.9

Авлагын голлох хэсгийг ХХС-ийн зээлийн авлага 167,660.2 мянган төгрөг, татаасны авлага 17,831.4 мянган төгрөг эзэлж байгаа бөгөөд зээлийн авлагыг тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй байна.

Өглөгийн голлох хэсгийг ОНХС-ын санхүүжилтийн өглөг 354,084.4 мянган төгрөг, барьцааны өглөг 41,208.1 мянган төгрөг эзэлж байгаа бөгөөд эдгээрийг тооцооны үлдэгдлийн баталгаагаар баталгаажуулаагүй байна.

2.3 Худалдан авах ажиллагааны бодлого төлөвлөлт

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Сэлэнгэ аймгийн Баянгол суманд улсын төсвөөс 20,323,400.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 3 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2024 оны 142 дугаар тогтоолын 2,3,4 дүгээр хавсралтаар 486,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 9 арга хэмжээ, сумын ИТХ-ын 2024 оны 110 дугаар хавсралтаар 3,261,083.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 24 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан байна.

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтаар Сэлэнгэ аймгийн Баянгол суманд улсын төсвөөс 18,125,500.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 2 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна. Сэлэнгэ аймгийн ИТХ-ын 2025 оны 12 дугаар тогтоолын 2,3,4 дүгээр хавсралтаар 2,177,670.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 7 арга хэмжээ, сумын ИТХ-ын 2025 оны 34 дүгээр хавсралтаар 3,646,928.9 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй 19 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр батлагдсан байна.

Хүснэгт 15. 2024 оны санхүүжилтийн эх үүсвэрийн задаргаа

Санхүүжилтийн эх үүсвэр	Төсөвт өртөг (мянган төгрөг)	Гэрээний дүн (мянган төгрөг)
1. Улсын төсвийн ХО	20,323,400	5,646,000
2. Аймгийн ХО	376,000	376,000
3. Аймгийн замын сан	60,000	60,000
4. Аймгийн ОНХС	50,000	49,900
5. Сумын ХО	36,200	36,200
6. ОНХС (шилжих)	22,183	22,183
7. ОНХС (шинэ)	2,893,701	1,928,509
МТА татвар	309,000	293,000
НИЙТ ДҮН	24,070,484	8,411,792

Хүснэгт 16. 2025 оны санхүүжилтийн эх үүсвэрийн задаргаа

Санхүүжилтийн эх үүсвэр	Төсөвт өртөг (мянган төгрөг)	Гэрээний дүн (мянган төгрөг)
-------------------------	---------------------------------	---------------------------------

1. Улсын төсвийн ХО	18,125,500	17,554,900
2. Аймгийн ХО	2,117,670	2,076,309
3. Аймгийн замын сан	60,000	59,811
4. Сумын ХО	143,960.80	131,373
5. ОНХС (шилжих)	1,977,968.10	1,107,180
5. ОНХС (шинэ)	1,421,346	1,036,976
МТА татвар	100,000	20,489
НИЙТ ДҮН	23,946,445	21,987,038

Аудитад хамрагдсан төсөл, арга хэмжээнүүдийн тендер шалгаруулалтын аргыг Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний жагсаалт"-ыг үндэслэн зөв сонгосон байна. Үнэлгээний хороог ТБОНХБАҮХАТХ, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8.1 дүгээр зүйл, Засгийн газрын 2024 оны 2 дугаар тогтоолыг үндэслэн хууль зүйн дагуу байгуулсан байна.

Тендерийн баримт бичгийн бүрдлийг шалгахад тендер шалгаруулалтын үр дүнгийн талаарх мэдэгдэл хүргүүлэхдээ батлагдсан маягыг ашиглаагүй Засаг даргын албан тоотоор хүргүүлсэн байна.

Мөн сумын төсвийн хөрөнгө оруулалтаар 54,460.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй ЗДТГ-ын цонхны засвар, 20,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй Цагдаагийн байрны засвар зэрэг чиг үүрэгт хамааралгүй төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна

Гэрээний хэрэгжилт ба Хяналтын сул тал

Доорх хүснэгтэд 2024 болон 2025 онд батлагдсан нийт төсөвт өртөг, байгуулсан гэрээний дүн, шилжүүлсэн санхүүжилтийн дүнг харьцуулан үзүүлэв.

Хүснэгт 17. Гэрээний хэрэгжилт

Үзүүлэлт	2024 (мянган төгрөг)	он 2025 (мянган төгрөг)	Өөрчлөлт	%
Нийт төсөвт өртөг	40,781,461	60,693,314	▲ +19,911,853	48.8%
Гэрээний нийт дүн	24,746,769	59,371,229	▲ 34,624,460	139.9%
Гэрээ/Төсвийн харьцаа	60.7%	97.8%	-	-

2025 онд гэрээний гүйцэтгэл 97.8% хүртэл өссөн — 2024 оны 60.7%-тай харьцуулахад мэдэгдэхүйц сайжирсан.

Барилгын ажлын зөвшөөрөл: Барилгын ажлын зөвшөөрөлгүй, эсвэл хугацаа нь дууссан байхад сунгалтгүйгээр ажлыг гүйцэтгэсэн байна. Захиалагч баримт бичгийн бүрдэлд тавих хяналт сул байна.

Гэрээний хугацаа сунгалт: Гэрээний хугацааг нотлох баримтгүйгээр удаа дараа сунгасан нь гүйцэтгэгчид алданги тооцох хууль эрх зүйн боломжийг хязгаарлаж, хөрөнгө оруулалтын үр өгөөжид сөргөөр нөлөөлөх эрсдэлийг бий болгосон.

Орон нутгийн хөгжлийн сан

ОНХС-аас санхүүжсэн төсөл арга хэмжээнүүдийн зарим хэсэг нь иргэдээс санал авч эрэмбэлэгдээгүй, зарим арга хэмжээ нь ТЕЗ-ийн чиг үүрэгт нийцэхгүй зэрэг асуудал илэрлээ. Эдгээр нь Орон нутгийн хөгжлийн сангийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, ТБОНХБАУХА тухай хуулийн болон Барилгын тухай хуулийн холбогдох заалтуудыг зөрчиж байна.

Эрх зүйн үндэс. Орон нутгийн хөгжлийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн дагуу ОНХС нь иргэдийн орлогын татварын орон нутгийн хувь, малын тоо толгойн татвар болон улсаас олгох санхүүгийн дэмжлэгийн эх үүсвэрүүдээс бүрддэг.

Санхүүжилтийн бүтэц. 2024–2025 оны ОНХС-ын зарцуулалтын бүтэц нь дараах хоёр үндсэн эх үүсвэрт тулгуурлаж байна:

- Орон нутгийн хөгжлийн сан (ОНХС) — нийт хөрөнгө оруулалт, нийгмийн дэд бүтцийн төслүүд
- Малын тоо толгойн татвар (МТТАТ) — мал аж ахуйн хөгжлийн зорилтот арга хэмжээ

Хүснэгт 18.ОНХС-ийн санхүүжилт

Эх үүсвэр	Нийт төсөвт өртөг (мян.төг)	Гэрээний дүн (мян.төг)	Шилжүүлсэн санхүүжилт (мян.төг)	Гүйцэтгэлийн хувь (%)
ОНХС 2024 (шилжих)	460,800	460,800	22,183	4.8%
ОНХС 2024 (шинэ)	1,948,509	1,928,509	1,446,371	75.0%
МТТАТ 2024	308,000	308,000	282,612	91.8%
Дүн	2,717,309	2,697,309	1,751,166	57.0%
ОНХС 2025 (шилжих)	1,977,968	1,107,180	862,570	43.6%
ОНХС 2025 (шинэ)	1,416,976	1,236,976	645,619	52.2%
МТТАТ 2025	53,489	20,489	20,489	100%
Дүн	3,448,433	2,364,645	1,528,678	44.3%
НИЙТ	6,165,742	5,061,954	3,279,844	53.2%

А. Шилжих хөрөнгө

Өмнөх оноос 2024 онд 237,555.0 мянган төгрөгийн 3 төсөл арга хэмжээ шилжсэн байна.

Хүснэгт 19. Өмнөх оноос шилжсэн төсөл арга хэмжээ /2024 он/

№	Ажлын нэр	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Гэрээ байгуулсан	Гэрээ дуусах	Гүйцэтгэгч	Санхүүжилт
1	Хүүхдийн тоглоомын талбай /чанарын баталгаа/	22,183	22,183	2022.04.20	100 хоног	Чингисийн төгөл ХХК	22,183
2	Үерийн далангийн ажил	260,350	260,000	2022.05.06	84 хоног	Дуулгат мөрөн ХХК	35,401
3	Халаалтын төвд уурын зуух шинээр худалдаж авах	300,000	299,952	2023.12.01	2024.03.13	Гом илч ХХК	179,971

Б. Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ

10 ажил хамрагдаж, нийт төсөвт өртөг 2,333,350.8 мянган төгрөг гэрээний дүн 1,368,556.8 мянган төгрөг шилжүүлсэн санхүүжилт 1,211,997.8 мянган төгрөг байна. Гэрээний биелэлт 88.6% байгаа нь өндөр үзүүлэлт боловч санхүүжилтийн биелэлт 74.0% байна.

Хүснэгт 20. Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ /2024 он

№	Ажлын нэр	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Гэрээ байгуулсан	Гэрээ дуусах	Гүйцэтгэгч	Санхүүжилт
1	Худаг гаргах /2 ш цооног/	20,000	20,000	2024.04.29	30 хоног	Бодь Хараа ХХК	20,000
2	Найрамдлын хэсгийн замыг хатуу хучилттай болгох	1,700,000	750,000	2024.09.06	2025.12.31	Огторгуйн бүтээл ХХК	738,908
3	Хүүхдийн тоглоомын талбай	220,862	219,800	2024.06.19	2024.07.19	Хүрэл соёмбо ХХК	131,880
4	Хогны машины засвар хүчин чадлыг нэмэгдүүлэх	20,000	20,000	2024.06.20	2024.06.25	Рааш Мандал ХХК	20,000
5	Цамхагт гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх	45,000	39,580	2024.05.06	30 хоног	Хүрэл соёмбо ХХК	24,573
6	Инженерийн шугам өргөтгөх	217,489	210,066	2024.06.19	30 хоног	Сэлэнгэ Ундрам ХХК	187,527
7	Сумын баяр наадмын зардал	35,000	34,111	2024.07.01	2024.07.06	Сумын ЗДТГ	34,111
8	Үер усны аюулаас сэргийлэх /Аврах завь мотор/	35,000	35,000	2024.04.23	30 хоног	Нанопланет ХХК	35,000
9	Зураг төсөв хийлгэх	20,000	20,000	—	—	—	0
10	Уурын зуухны засвар	20,000	20,000	2024.09.05	60 хоног	Ануужээ ХХК	20,000

В. Малын тоо толгойн албан татвараар санхүүжих төсөл арга хэмжээ

9 ажил төлөвлөж, нийт төсөвт өртөг 309,000 мянган төгрөг гэрээний дүн 293,000 мянган төгрөг санхүүжилт 282,611 мянган төгрөг байна. Биелэлт 94.8%.

Хүснэгт 21. ОНХС-ийн МТТАТ -аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ 2024 он

№	Ажлын нэр	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Гэрээ байгуулсан	Гэрээ дуусах	Гүйцэтгэгч	Санхүүжилт
1	Сэг зэм, нохой устгал	15,000	15,000	2024.03.01	2024.10.01	Тэс петролим ХХК, иргэн Ганбаатар	11,934
2	Зохиомол хээлтүүлэг — эхо аппарат	45,000	45,000	2024.05.01	30 хоног	Атар ирээдүй ХХК	33,550
3	Худаг шинээр гаргах	60,000	60,000	2024.05.09	30 хоног	Бимм ХХК	57,073
4	Хонь хяргагч төхөөрөмж худалдан авах	60,000	60,000	2024.05.20	15 хоног	УБ Бизнес Консалтинг ХХК	55,000
5	Өтөг бууц цэвэрлэх бага оврын ковш	60,000	60,000	—	—	Ургац өргөө ХХК	56,800
6	Малчдын зөвлөгөөн сургалт, өдөрлөг	15,000	15,000	2024.08.01	30 хоног	Сумын ЗДТГ	14,300
7	Малын эрүүл мэнд — вакцин, ариутгал	15,000	14,000	2024.07.01	100 хоног	Атар ирээдүй ХХК	14,955
8	Малын удам сайжруулах эцэг мал	20,000	20,000	2024.04.16	30 хоног	А.Амармөнх	20,000
9	Сэг зэм устгалын цэг байгуулах	19,000	19,000	2024.05.02	14 хоног	Грузин Отгоо ХХК	19,000

III. 2025 ОНЫ ОНХС-ЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ

А. Шилжих хөрөнгө

4 ажил шилжин ирсэн бөгөөд нийт 1,977,968 мянган төгрөгийн дүн бүртгэгдсэн. Энэ нь 2024 оны шилжих хөрөнгө (582,533 мянган төгрөг)-тэй харьцуулахад 3.4 дахин нэмэгдсэн байна. Гэрээний биелэлт болон санхүүжилт дутуу байгаа тохиолдол бий.

Хүснэгт 22. Өмнөх оноос шилжсэн төсөл арга хэмжээ /2025 он/

№	Ажлын нэр	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Гэрээ байгуулсан	Гэрээ дуусах	Гүйцэтгэгч	Санхүүжилт
1	Зураг төсөв хийлгэх	20,000	20,000	2025.06.01	2025.12.31	—	—

№	Ажлын нэр	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Гэрээ байгуулсан	Гэрээ дуусах	Гүйцэтгэгч	Санхүүжилт
2	Найрамдлын хэсгийн замыг хатуу хучилттай болгох	1,698,589	959,681	2024.09.06	2025.12.31	Огторгуйн бүтээл ХХК	849,542
3	Хүүхдийн тоглоомын талбай	219,800	87,919	2024.06.19	2024.07.19	Хүрэл соёмбо ХХК	—
4	Цамхагт гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх	39,580	39,580	2024.05.06	2024.06.06	Хүрэл соёмбо ХХК	13,028

Б. Шинээр эхлэх хөрөнгө оруулалт

9 ажил төлөвлөсөн, нийт төсөвт өртөг 1,425,000 мянган төгрөг гэрээний дүн 1,036,976 мянган төгрөг байна. Камержуулалт (180,000 мян.төг) болон Гэрэлтүүлэг (200,000 мян.төг) хоёр ажлын тендер шалгаруулалт 1-3 удаа зарласан боловч оролцогч байхгүйгээс хэрэгжээгүй.

Хүснэгт 23. Шинээр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ /2025 он/

№	Ажлын нэр	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Гэрээ байгуулсан	Гэрээ дуусах	Гүйцэтгэгч	Санхүүжилт
1	Камержуулалт	180,000	—	—	—	—	—
2	Гэр хорооллын гудамж хатуу хучилттай зам тавих	750,000	746,346	2025.06.01	2026.05.01	Мажестик Солюшн Рөүд ХХК	368,000
3	Хогны шинэ машин худалдаж авах	90,000	86,000	2025.05.28	2025.06.28	ЭМНМ ХХК	86,000
4	Гэрэлтүүлэг	200,000	—	—	—	—	—
5	ХАА-н гадаа зогсоол, саравч /зураг төсөв/	20,000	20,000	2025.05.01	2025.10.01	Бурхант орд ХХК	10,000
6	Сумын баяр наадмын үйл ажиллагаа	50,000	50,000	2025.07.01	2025.07.06	ЗДТГ	50,000
7	Баян багийн 2-р хэсгийн худаг цахим болгох	15,000	15,000	2025.05.28	2025.06.28	Баялаг говь ХХК	15,000
8	Ногоон байгууламж нэмэгдүүлэх	20,000	20,000	2025.05.01	2025.11.01	Иргэн А.Жаргал	20,000
9	Гэр хорооллын гудамжны зам засварлах	100,000	99,630	2025.05.20	2025.07.01	Мажестик Солюшн Рөүд ХХК	96,619

В. Малын тоо толгойн албан татвараар санхүүжих төсөл арга хэмжээ

6 ажил төлөвлөсөн, нийт төсөвт өртөг 100,000 мянган төгрөг гэрээний дүн 20,489 мянган төгрөг биелэлт зөвхөн 20.5%. Худаг гаргах ажлын гүйцэтгэгч байхгүй байна. Худаг гаргах 33,000.0 мянган төгрөгийн төсөв өртөгтэй ажил хэрэгжээгүй

Хүснэгт 24. ОНХС-ийн МТТАТ -аар хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээ 2025 он

№	Ажлын нэр	Төсөвт өртөг	Гэрээний дүн	Гэрээ байгуулсан	Гэрээ дуусах	Гүйцэтгэгч	Санхүүжилт
1	Сэг зэм, нохой устгал	15,000	4,660	2025.03.01	2025.12.31	Ш.Отгонбат, Х.Нэмэхбаяр	4,660
2	Малын эрүүл мэнд	12,000	3,834	2025.03.01	2025.12.31	Мал эмнэлгүүд	3,834
3	Малын удам сайжруулах	20,000	950	2025.03.01	2025.12.01	ЗДТГ	950
4	Худаг гаргах	33,000	—	—	—	—	—
5	Гүүр засварлах	10,000	1,045	2025.05.01	2025.11.01	Баян багийн иргэд	1,045
6	Малчдын зөвлөгөөн, семинар	10,000	10,000	2025.04.01	2025.10.31	ЗДТГ	10,000

Хоршоог хөгжүүлэх сангийн бүрдүүлэлт, зарцуулалт

Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журмын 2.1.1-д зааснаар сангийн хөрөнгийг улсын болон орон нутгийн төсвөөс олгох хөрөнгөөс бүрдүүлэх бөгөөд журмын 3.3.1-д зааснаар ИТХ нь сангийн орлого, зарлага болон төсвийг батална.

Хүснэгт 25. Хоршоог хөгжүүлэх сангийн санхүүжилт

Тайлант он	ИТХ-ын батлагдсан санхүүжилт (төг)	Гүйцэтгэл (төг)	Зөрүү (төг)	Нийцэл
2024	130,730,000	107,249,144	23,480,856	Тийм
2025	202,920,600	72,343,213	130,577,387	тийм

Тайлбар: ИТХ-аар батлагдсан санхүүжилт зарцуулагдаагүй үлдэгдэл нь зээлийн эргэн төлөлтийн хуваарьтай холбоотой бөгөөд журмын 2.10-д зааснаар "эх үүсвэрийн 15-аас доошгүй хувийг бүрдүүлсэн тохиолдолд" дараагийн сонгон шалгаруулалт зарлах эрхтэй.

Хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгийн зарцуулалт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 6.10-д зааснаар сумын Засаг дарга зээлдэгчийн талаарх баримт бичгийг эх хувиар нь баримтжуулан хадгалах үүрэгтэй. Аудитаар 2024-2025 онд олгогдсон 2 хоршооны зээлийн хувийн хэргийн бүрдэлд тулган баталгаажуулалт хийлээ.

Хүснэгт 26. Хувийн хэргийн бүрдүүлэлт

№	Баримт бичгийн төрөл	Журмын заалт	Булгансүүлт (2024) 30.0 сая төг	Баядсүрэг (2025) 40.0 сая төг
1	Хорооны сонгон шалгаруулалтын шийдвэр	Журам 3.3.2, 6.6	✓	✓
2	Зээлдэгчийн анкет	Журам 6.10.1	✓	✓
3	Зээл олгохыг хүссэн өргөдөл	Журам 6.10.2	✓	✓
4	Оршин суугаа газрын тодорхойлолт	Журам 6.10.3	✓	✓
5	Төслийн баримт бичиг	Журам 6.10.4	✓	✓
6	Хорооны хурлын тэмдэглэл	Журам 6.10.5	✓	✓
7	Зээлийн болон барьцааны гэрээ	Журам 3.4.3, 6.8, 6.10.6	✓	✓
8	Барьцаа хөрөнгийн үнэлгээ, барьцаалбар	Журам 3.4.4, 6.10.7	✓	✓
9	Зээлийн эргэн төлөлтийн хуваарь	Журам 6.10.8	✓	✓
10	Шаардлага, шалгуурыг хангасан баримт	Журам 6.10.9	✓	✓
11	Хоршооны хөгжлийн төлөвлөгөө	Журам 6.10.10	✗	✗
НИЙТ БҮРДЭЛ			10/11 – ХАНГАЛТТАЙ	10/11 – ХАНГАЛТТАЙ

Зээлийн үлдэгдэл

Хүснэгт 27. Зээлийн авлагын харьцуулалт

Үзүүлэлт	2024 он	2025 он	Өөрчлөлт
Зээлдэгчийн тоо	12	12	-
Үндсэн зээл	186,300 мянган төгрөг	158,900 мянган төгрөг	-27,400 мянган төгрөг
Хүү	9,400 мянган төгрөг	7,500 мянган төгрөг	-1,900 мянган төгрөг
Алданги	960 мянган төгрөг	930 мянган төгрөг	-30 мянган төгрөг
Нийт авлага	196,600 мянган төгрөг	167,300 мянган төгрөг	-29,300 мянган төгрөг

Зээлийн нийт үлдэгдэл 2024-2025 онд 29,293.2 мянган төгрөгөөр буурсан нь эргэн төлөлтийн явцыг харуулж байна.

Зээлийн олголтын байдал

- 2024 онд Хоршоог хөгжүүлэх сангаас 1 зээлдэгчид 30,000 мянган төгрөгийн зээл олгосон байна.

- 2025 онд 202,900 мянган төгрөгийн батлагдсан төсөвтэй байснаас 1 зээлдэгчид 40,000 мянган төгрөгийн зээл олгож, батлагдсан төсвийн 19.7 хувийг ашигласан байна.

Хүснэгт 28. Зээлийн олголтын харьцуулалт

Үзүүлэлт	2024 он	2025 он	Өөрчлөлт
Батлагдсан төсөв	0	202,900 мянган төгрөг	+202,900 мянган төгрөг
Зээлдэгчийн тоо	1	1	-
Олгосон зээлийн дүн	30,000 мянган төгрөг	40,000 мянган төгрөг	+10,000 мянган төгрөг
Төсвийн ашиглалт	-	19.7%	-

ЗОХИСТОЙ ХАРЬЦААНЫ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН НИЙЦЭЛ

Журмын 7.1-д заасан 6 шалгуур үзүүлэлтийн дагуу 2024, 2025 оны гүйцэтгэлийг үнэлэв:

Хүснэгт 29. Зохистой харьцааны шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Зохистой харьцаа (Журам 7.1)	2024 он	2025 он	Дүгнэлт
1	Зээлийн эргэн төлөлт	Нийт хөрөнгийн $\geq 30\%$	17.1%	21.7%	ХАНГААГҮЙ
2	Чанаргүй зээлийн хэмжээ	Нийт хөрөнгийн $< 10\%$	Хангасан	Хангасан	ХАНГАСАН
3	Хяналт тавих үйл ажиллагаа	Жилд ≥ 2 удаа	0 удаа	0 удаа	ХАНГААГҮЙ
4	Олон нийтэд тайлагнасан	Жилд ≥ 1 удаа	Үгүй	Үгүй	ХАНГААГҮЙ
5	Тайлан, мэдээ	Улирал бүр	Тийм	Тийм	ХАНГАСАН
6	Ажлын байр нэмэгдүүлсэн	$> 10\%$ нэмэгдсэн	Тодорхойгүй	Тодорхойгүй	ҮНЭЛЭГДЭЭГҮЙ

Зээлийн эргэн төлөлт 30%-ийн шаардлага хангаагүй

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 7.1-д "Зээлийн эргэн төлөлтөд нийт хөрөнгийн 30-аас доошгүй хувийг бүрдүүлсэн байх" шаардлагыг 2024 онд 12.9 нэгж хувь, 2025 онд 8.3 нэгж хувиар хангаагүй байна.

Хүснэгт 30. Зээлийн шалгуур

Тайлант он	Нийт хөрөнгө (төг)	Эргэн төлөгдсөн (30%-ийн шаардлага)	Гүйцэтгэл (%)	Зөрүү (нэгж хувь)
2024	196,579,618	≥58,973,885	17.1%	-12.9%
2025	167,286,404	≥50,185,921	21.7%	-8.3%

Олон нийтэд тайлагнаагүй

2024-2025 онд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/361 дүгээр тушаалаар батлагдсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын

- **Журам 7.1** "Олон нийтэд тайлагнасан байх — Жилд 1-ээс дээш" — хоёр жилд хоёуланд нь тайлагнаагүй.
- **Журам 3.4.6:** "Сангийн санхүүгийн болон үйл ажиллагааны тайланг Төсвийн тухай хуульд заасан хугацаанд тухайн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах" — Засаг даргын үүрэг биелэгдээгүй.
- **Журам 7.10:** "Зээлдэгч нь... төслийн талаарх тайланг жилд нэг удаа сумын иргэд, олон нийтэд тайлагнана" — зээлдэгч хоршоодын тайлагнал хийгдээгүй.

3. АУДИТААР ИЛРҮҮЛСЭН АСУУДАЛ

ЗАСАГЛАЛ, ДОТООД ХЯНАЛТ БА ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Илэрсэн асуудал 4.1	Хөтөлбөрийн биелэлт зорилтот түвшинд хүрч чадаагүй — нийт 253 арга хэмжээ (58.3%) "үр дүнгүй"
Асуудлын ангилал	Нөлөө өндөр

Бодит байдал: МУ-ын ЗГ-ийн 2025 оны 43 тогтоолын журмын 6.5.1-ийн дагуу үнэлэхэд Баянгол сумын ЗДТГ-ийн 2025 оны ХЖТ болон МУЗГҮАХ 2024-2028-ийн нийт 434 арга хэмжээний 253 нь (58.3%) зорилтот түвшний 85%-д хүрч чадаагүй байна. Ангиллаар задлан үзэхэд:

■ Үр дүн гараагүй (0–29%) — 131 арга хэмжээ (30.2%)

ХЖТ-д 54, МУЗГҮАХ-д 77 арга хэмжээ энэ ангилалд орсон. Хамгийн хүнд нөхцөл байдал:

- 2.3. Эрүүл мэнд (ХЖТ): 18 арга хэмжээ бүгд 0–29%, дундаж 0.7% — телемедицин, байгууллагын хүчин чадал, чадварлаг эмч хөтөлбөр, эрт илрүүлэг үзлэг зэрэг нь огт хэрэгжилгүй
- 2.4. Биеийн тамир (ХЖТ): 8 арга хэмжээ бүгд 0–29%, дундаж 0.9%
- 3.6. Төсөв, санхүүгийн бодлого (ХЖТ): 6 арга хэмжээ бүгд 0–29%, дундаж 0.9%
- 4.1. Цахим засаглал (ХЖТ): 13-аас 11 нь 0–29%, дундаж 8.1% — "Ухаалаг цэг", цахим өргөдлийн тогтолцоо, программ хангамж зэрэг нь огт хэрэгжилгүй
- 2.2. Соёл, урлаг (ХЖТ): 6-аас 5 нь 0–29% — "Нүүдэлчин" фестиваль, шавь сургалт, жүжиг огт хэрэгжилгүй
- 2.2.1. Боловсрол (МУЗГҮАХ): 46-аас 28 нь 0–29%, дундаж 23.0% — шинэчилсэн хөтөлбөрийн хэрэглэгдэхүүн, лаборатори, сурах бичиг огт хангагдаагүй
- 3.4.1. Биологийн олон янз байдал (МУЗГҮАХ): 8-аас 7 нь 0–29%, дундаж 8.8%
- 3.4.3. Ногоон эдийн засаг (МУЗГҮАХ): 5-аас 4 нь 0–29%, дундаж 10.0%
- 4.2.3. Төрийн албаны реформ (МУЗГҮАХ): 2-оос 2 нь 0–29%, дундаж 0.0%

■ Үр дүн хангалтгүй (30–59%) — 53 арга хэмжээ (12.2%)

ХЖТ-д 9, МУЗГҮАХ-д 44 арга хэмжээ энэ ангилалд орсон. Гол хүндрэлтэй чиглэл:

- 3.3.4. ХАА — Хоршоо, Чинээлэг мал (МУЗГҮАХ): 17-оос 9 нь 30–59%, дундаж 42.4%

- 3.4.2. Уур амьсгалын өөрчлөлт (МУЗГҮАХ): 11-ээс 6 нь 30–59%, дундаж 21.8%
- 2.2.3. Багшлах хүний нөөц (МУЗГҮАХ): 6-аас 3 нь 30–59%, дундаж 30.0%
- 3.4. Байгаль орчин (ХЖТ): 4-өөс 2 нь 30–59%, дундаж 42.5%

■ Үр дүн хүлээгдэж байгаа (60–84%) — 69 арга хэмжээ (15.9%)

ХЖТ-д 22, МУЗГҮАХ-д 47 арга хэмжээ энэ ангилалд орсон. Жаахан нэмэлт дэмжлэг авбал зорилтдоо хүрэх боломжтой арга хэмжээнүүд:

- 2.5. Хүүхэд, залуучууд, гэр бүл (ХЖТ): 4 арга хэмжээ бүгд 60–84%, дундаж 70.0%
- 2.6. Хөдөлмөр эрхлэлт, НДД (ХЖТ): 4 арга хэмжээ 60–84%, дундаж 63.3%
- 2.2.1. Боловсрол (МУЗГҮАХ): 10 арга хэмжээ 60–84% — нэмэлт анхаарал хандуулбал зорилтод хүрэх боломжтой
- 2.1.1. Гэр бүл, хүн амын бодлого (МУЗГҮАХ): 5 арга хэмжээ 60–84%

Шалгуур, эрх зүйн үндэслэл: МУ-ын ЗГ-ийн 2025 оны 43 тогтоолоор батлагдсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 6 дугаар зүйлийн 6.5-ын 1 дэх хэсэг: хэрэгжилтийн явц зорилтот түвшний 85 хувь буюу түүнээс дээш бол "үр дүнтэй"

Асуудлын үндсэн шалтгаан: Хэрэгжилтийн хяналт-шинжилгээний тогтолцоо улирлаар хийгддэггүй — алдааг эрт илрүүлэх механизм байхгүй 2. Дотоод хяналт сул

Нөлөөлөл ба үр дагавар ХЖТ болон МУЗГҮАХ-ийн тэн хагасаас илүү (58.3%) биелэгдэхгүй байгаа нь орон нутгийн хөгжлийн зорилтод шууд сөргөөр нөлөөлж байна. Ялангуяа боловсролын чанар, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмж, цахим засаглалын хөгжил, байгаль орчны хамгаалал зэрэг иргэдийн эрхэд нөлөөлөх чиглэлүүд удаашрах эрсдэлтэй.

Зөвлөмж

Хэрэгжилт нь зорилтот түвшний 85 хувьд хүрээгүй арга хэмжээнүүдэд дүн шинжилгээ хийж, тасарсан болон хангалтгүй хэрэгжсэн арга хэмжээг эрчимжүүлэх төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийн үр дүнг сайжруулж ажиллах.

Илэрсэн асуудал 4.2	Дотоод хяналтын давтамж нэмэгдсэн боловч эрсдэлийн удирдлага бүрэн төлөвшөөгүй байна
Асуудлын ангилал	Нөлөө дунд
Бодит байдал	<p>Сэлэнгэ аймгийн ЗДТГ-ын ХШҮ-ний хэлтсээс хийсэн жилийн эцсийн үнэлгээгээр Баянгол сумын бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээг 2025 оны нийт үнэлгээ 69.43 хувь болж, 2024 оны 84.03 хувийн үнэлгээнээс 14.6 хувиар буурсан байна.</p> <p>Дотоод хяналтын давтамж нэмэгдсэн хэдий ч санхүүгийн зөрчил дутагдлууд гарсан хэвээр байна:</p> <ul style="list-style-type: none"> • Эрсдэлийн удирдлага, урьдчилан сэргийлэх хяналтын тогтолцоо бүрэн төлөвшөөгүй • Дотоод хяналтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах нэгдсэн механизм байхгүй • Эрсдэлийг урьдчилан тодорхойлох, бүртгэх, бууруулах зохион байгуулалт хангалтгүй
Шалгуур, эрх зүйн үндэслэл	<p>Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолын хавсралт "Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг Зохион байгуулах нийтлэг журам"-ын 1.5. Энэхүү журмын 1.4-т зааснаас бусад тохиолдолд "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-ыг тухайн байгууллага, аж ахуйн нэгж өөрөө баталж мөрдөнө. 3.1. Энэхүү журмын 1.3-т заасан "Дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам"-д өөрөөр заагаагүй бол дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах үүргийг тухайн аж ахуйн нэгж, байгууллагын захиргааны асуудал хариуцсан нэгж, ажилтан (цаашид "дотоод хяналт шалгалтын нэгж, ажилтан" гэх) гүйцэтгэнэ</p>

Асуудлын үндсэн шалтгаан	Дотоод хяналтын талаарх ойлголт, арга зүйн чадавх сул, ISO 9001 стандартын хэрэгжүүлээгүй
Нөлөөлөл ба үр дагавар	Алдаа, зөрчлийг цаг тухайд нь илрүүлэх, таслан зогсоох боломжийг хязгаарлана.
Зөвлөмж	1. Дотоод хяналт, хяналт-шинжилгээ, эрсдэлийн удирдлагын тогтолцоог сайжруулах 2. Эрсдэлийн матрицыг жил бүр шинэчлэн батлуулах, хэрэгжилтийг хангах

ТӨСӨВ, САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Илэрсэн асуудал 4.3	Орлогын төлөвлөлт бодит нөхцөлтэй бүрэн уялдаагүй байна
Асуудлын ангилал	Нөлөө дунд
Бодит байдал	Зарим орлогын эх үүсвэрийн төлөвлөлт бодит үндэслэлгүй байна: <ul style="list-style-type: none"> • Үйл ажиллагааны орлогын албан татварын биелэлт 2024 онд 199.6%, 2025 онд 30.3% болсон (нэг удаагийн орлогыг суурь болгон ашигласан) • Хөрөнгийн орлогын биелэлт 2024 онд 969.6%, 2025 онд 53.4% болсон (хэт өндрөөр тооцсон) • Хог хаягдлын үйлчилгээний хураамж 3.3 дахин нэмэгдүүлсэн боловч 84.6% биелэлттэй • Хүү, торгуулийн орлого бодлогын орчны өөрчлөлтийг тооцоогүйгээр төлөвлөсөн
Шалгуур, эрх зүйн үндэслэл	Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1.-д "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"
Асуудлын үндсэн шалтгаан	Орлогын төлөвлөлтөд эрсдэлийн үнэлгээ, бодит тооцоолол хангалтгүй хийгдсэн.
Нөлөөлөл ба үр дагавар	Орлогын хэт өндөр төлөвлөлтөөс үүдэн зарцуулалтын төлөвлөгөөтэй уялдаа алдагдаж, санхүүгийн хомсдол үүсэх эрсдэлтэй.
Зөвлөмж	2027 оны Орлогын төлөвлөлтийг бодит нөхцөлтэй уялдуулж, орлогын эх үүсвэр бүрд эрсдэлийн үнэлгээ хийж, бодит суурь тооцооллыг ашиглах Нэг удаагийн орлогыг ирээдүйн суурь болгон ашиглахгүй байх дотоод журам мөрдүүлэх

Илэрсэн асуудал 4.4	Малын тоо толгойн албан татварын орлогын төвлөрүүлэлт хангалтгүй байна
Асуудлын ангилал	Нөлөө дунд
Бодит байдал	<ul style="list-style-type: none"> • 2024 онд малын тоо толгойн албан татварын төлөвлөгөө 309,000 мянган төгрөг, гүйцэтгэл 130,600 мянган төгрөг — 42.3% биелэлт, 178,400 мянган төгрөг дутуу • 2024 онд 230,100 мянган төгрөг, 2025 оны хагас жилд 211,400 мянган төгрөг-ийн татварын авлага үүссэн
Шалгуур, эрх зүйн үндэслэл	Малын тоо толгой албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйл Албан татвар ногдуулах, малын тоо толгойг тодорхойлох: 5.2-д "Тухайн татварын жилд албан татвар ногдуулах малын тоо толгойг Статистикийн тухай хуульд заасны дагуу хийгдсэн өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн татварын алба тооцож, төлбөл зохих албан татварыг тодорхойлно."

Асуудлын үндсэн шалтгаан	Мал тооллогын дүнд суурилсан бодит нэхэмжлэл хийгдэхгүй, хураалтын хяналт сул байгаатай холбоотой.
Нөлөөлөл ба үр дагавар	Орлогын алдагдал болон хуримтлагдсан авлага орон нутгийн төсвийн санхүүгийн чадавхыг бууруулна.
Зөвлөмж	Малын тоо толгойн албан татварын орлогын төлөвлөгөөг өмнөх жилийн мал тооллогын дүнд үндэслэн

Илэрсэн асуудал 4.5	Төсвийн хөрөнгийг зохистой удирдаагүйн улмаас тоног төхөөрөмжийн зардлыг батлагдсан төсвөөс 65.9 хувь буюу 157,808.2 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зөв төлөвлөөгүй, санхүүгийн тайланд үнэн зөв тусгаагүй, мөн төсвийн зардлын бүлэг, арга хэмжээ хооронд зохих журмын дагуу зохицуулалт хийгээгүй байна.
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал	<ul style="list-style-type: none"> • 2025 онд тоног төхөөрөмжийн зардалд 124,500 мянган төгрөг төсөвлөсөн боловч 206,600 мянган төгрөг зарцуулж, батлагдсан төсвөөс 82,100 мянган төгрөг-өөр (65.9%) давсан. Аудитаар уг зарцуулалтын бүрэлдэхүүнийг шалгахад 157,808.2 мянган төгрөг нь барилга байгууламжийн шинж чанартай зардал (хатуу хучилттай зам 118,135.0 мянган төгрөг, гэрэлтүүлгийн ажил 14,673.2 мянган төгрөг, ногоон байгууламж 20,000.0 мянган төгрөг, цахим худаг 5,000.0 мянган төгрөг) байтал 222001 "Тоног төхөөрөмж" ангиллаар буруу гаргасан байна • ИТХ-ын нэмэлт зөвшөөрөлгүйгээр батлагдсан хэмжээнээс давуулан зарцуулсан. Зөвхөн хот тээврийн машин 29,340.0 мянган төгрөг болон Киоск машин 19,500.0 мянган төгрөг (нийт 48,840.0 мянган төгрөг) нь 222001 "Тоног төхөөрөмж" ангилалд зөв хамаарна.
Шалгуур, эрх зүйн үндэслэл	Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Сангийн сайдын 2018 оны 6 сарын 8-ны өдрийн 134 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Төсөвт зохицуулалт хийх журам"-ын 3.1.6 дахь "Төсвийн тухай хуулийн 42.4-т заасны дагуу дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх." . Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын 220001 "Барилга байгууламж", 222001 "Тоног төхөөрөмж" ангиллын тодорхойлолтын дагуу барилга байгууламжийн шинж чанартай зардлыг 220001-д ангилах.
Асуудлын үндсэн шалтгаан	Урьдчилсан хяналт болон зарцуулалтын хяналтын механизм сул байгаатай холбоотой.
Нөлөөлөл ба үр дагавар	Төсвийн сахилга зөрчигдөж, бусад зардлын санхүүжилтэд нөлөөлнө.
Албан шаардлага	Төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зөв төлөвлөн бүртгэх, санхүүгийн тайланд үнэн зөв тусгах, мөн төсвийн зардлын бүлэг, арга хэмжээ хоорондын зохицуулалтыг холбогдох хууль, журамд нийцүүлэн хэрэгжүүлж ажиллах.

ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САН (ОНХС) БА ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ САНГИЙН ХӨРӨНГИЙН ЗАРЦУУЛАЛТ

Илэрсэн асуудал 4.6	Иргэдийн санал аваагүй, зураг төсөв, тооцоо судалгааг урьдчилан хийгээгүй 2024 онд 2,087,488.6 мянган төгрөгийн 6 төсөл арга хэмжээ, 2025 онд 783,000.0 мянган төгрөгийн 2 төсөл арга хэмжээ, нийт 2,870,488.6
----------------------------	--

	мянган төгрөгийн өртөг бүхий 8 төсөл, арга хэмжээг ОНХС-ийн хөрөнгөөр төлөвлөж баталсан байна
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал	<p>Баянгол сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2023 оны 06 дугаар сарын 25-ны өдөр багийн ИНХ-аас ирүүлсэн иргэдийн саналд үнэлгээ хийж, 2024 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр нийт 16 төсөл, арга хэмжээг, мөн сумын Засаг даргын 2024 оны А/167 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 2024 оны 07 дугаар сарын 05-ны өдөр багийн ИНХ-аас ирүүлсэн иргэдийн саналд үнэлгээ хийж, 2025 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр нийт 3 төсөл, арга хэмжээг сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжих 14 төсөл арга хэмжээг тус тус эрэмбэлэн нэгтгэж баталгаажуулсан байна.</p> <p>Гэтэл дараах төсөл арга хэмжээнүүд нь иргэдийн санал аваагүй, зураг төсөвгүй Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар баталсан 2024-2025 оны төсөвт тусган төсөл арга хэмжээг хэрэгжүүлсэн байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> • Найрамдлын хэсгийн замыг хатуу хучилттай болгох 1,700,000.0 мянган төгрөг 00 мөнгөний төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээ (2024 он) • Инженерийн шугам өргөтгөх 217,488.6 мянган төгрөг 00 мөнгөний төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээ (2024 он) • Үер усны аюулаас сэргийлэх (аврах завь, мотор) 35,000.0 мянган төгрөг 00 мөнгөний төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээ (2024 он) • Худаг шинээр гаргах 60,000.0 мянган төгрөг 00 мөнгөний төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээ (2024он) • Өтөг бууц цэвэрлэх бага оврын ковш худалдаж авах 60,000.0 мянган төгрөг 00 мөнгөний төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээ (2024он) • Малчдын зөвлөгөөн, сургалт, өдөрлөг 15,000.0 мянган төгрөг 00 мөнгөний төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээ (2025 он) • Худаг гаргах 33,000.0 мянган төгрөг 00 мөнгөний төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээ (2025 он) • Гэр хорооллын гудамж хатуу хучилттай зам тавих 750,000.0 мянган төгрөг 00 мөнгөний төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээ (2025 он)
Шалгуур, эрх зүйн үндэслэл	Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-д "Төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан "орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.3.2-д "ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл нь тухайн орон нутгийн иргэдийн саналаар дэмжигдэж эрэмбэлэгдсэн байх", Журмын 4.7.5-д "Орон нутгийн иргэдийн саналыг аваагүй зардлыг баталж санхүүжүүлэхийг хориглосон", Журмын 3.5.1, 5.2, 5.6-д "Баг, хорооны Засаг дарга жил бүр иргэдээс санал авах ажлыг зохион байгуулах"
Асуудлын үндсэн шалтгаан	Иргэдийн оролцооны механизмыг хэрэгжүүлэх дотоод хяналт болон хариуцлагын тогтолцоо хангалтгүй байгаатай холбоотой.
Нөлөөлөл ба үр дагавар	ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт иргэдийн бодит хэрэгцээ, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй болж, хуулийн зөрчил үүснэ. Иргэдийн төрийн байгуулалтад итгэх итгэл буурна.
Албан шаардлага	2027 онд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг иргэдийн саналд үндэслэн эрэмбэлж, дэмжигдсэн төсөл, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлж ажиллах.

Илэрсэн асуудал 4.7	МТТАТ-ын хөрөнгийг чиг үүрэгт хамааралгүй нохой устгах төсөл арга хэмжээг санхүүжүүлж 2024 онд 2,700.7 мянган төгрөг, 2025 онд 5,091.5 мянган төгрөг, нийт 7,792.2 мянган төгрөгийг зарцуулсан байна
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал	Малын тоо толгойн татварын орлогоор мал аж ахуйн хөгжилтэй шууд холбоогүй дараах арга хэмжээг санхүүжүүлсэн байна: 2024 онд Нохой устгал — 2,700.7 мянган төгрөг 2025 онд Нохой устгал — 5,091.5 мянган төгрөг Нийт нохой устгах ажилд 7,792.2 мянган төгрөгийн чиг үүрэгт хамааралгүй санхүүжилт олгосон байна.
Шалгуур, эрх зүйн үндэслэл	Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, 22 дугаар зүйлийн 22.1-д “Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана”, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаа батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.6.ОНХС-ийн хөрөнгийг зөвхөн дараах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулах ба өөр бусад зорилгоор зарцуулахгүй:
Асуудлын үндсэн шалтгаан	Төсвийн тухай хуулийн холбогдох заалт болон “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.6.ОНХС-ийн хөрөнгийг зөвхөн дараах хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд зарцуулах ба өөр бусад зорилгоор зарцуулахгүй:
Нөлөөлөл ба үр дагавар	Мал аж ахуйн хөгжилд зориулагдсан орлогын эх үүсвэр буруу зориулалтаар зарцуулагдаж, журмын зорилтыг биелүүлэхгүй болно.
Зөвлөмж	2026 онд МТТАТ-ын хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг холбогдох хууль, журамд нийцүүлэн төлөвлөж, зөвхөн зориулалтын чиглэлээр зарцуулж ажиллах.

Илэрсэн асуудал 4.8	Байгууллагын урсгал болон хөрөнгийн зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой ЗДТГ-ын байрны цонхны засвар, цагдаагийн хэсгийн байрны засвар, спорт заалны өмнөх талбай бетондох зэрэг 124,460.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй, 3 төсөл арга хэмжээг төлөвлөж зарцуулсан байна.
Асуудлын ангилал	Нөлөө их
Бодит байдал	ОНХО-ын төсөл арга хэмжээний Их засварын зардалд байгууллагын урсгал үндсэн үйл ажиллагааны урсгал болон хөрөнгийн зардлаар санхүүжих боломжтой дараах төсөл арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд: <ul style="list-style-type: none"> • ЗДТГ-ын байрны цонхны засвар 54,460.8 мянган төгрөг • Цагдаагийн хэсгийн байрны засвар 20,000.0 мянган төгрөг, • Спорт заалны өмнөх талбай бетондох 50,000.0 мянган төгрөг Нийт 124,460.8 мянган төгрөг-ийн 3 төсөл арга хэмжээ байна.
Шалгуур, эрх зүйн үндэслэл	Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24. "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг”, 22 дугаар зүйлийн 22.1.Төсвийг тогтоосон ангиллын дагуу төлөвлөж, гүйцэтгэлийг хэрэгжүүлж, бүртгэн, тайлагнана”

Асуудлын үндсэн шалтгаан	Тендер эхлэхийн өмнө зураг төсөв бэлтгэх урьдчилсан хяналтын механизм байхгүй байгаатай холбоотой.
Нөлөөлөл ба үр дагавар	Ажлын чанар, хүлээн авах стандарт тодорхойгүй болж, санхүүгийн хохирол болон дутуу чанарын ажил гүйцэтгэгдэх эрсдэл нэмэгдэнэ.
Зөвлөмж	2026 онд ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хууль, журамд заасан зориулалт, шалгуурт нийцүүлэн төлөвлөж, байгууллагын урсгал үйл ажиллагаатай холбоотой зардлыг санхүүжүүлэхгүй байх.

Илэрсэн асуудал 4.9	Барилга байгууламжийг ажил эхлүүлэх зөвшөөрөлгүйгээр 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж хууль, журмын шаардлагыг зөрчсөн.
Асуудлын ангилал	Нөлөө дунд
Бодит байдал	2024 онд Барилгын тухай хуулийн 7.1 дүгээр зүйлд заасан ажил эхлүүлэх зөвшөөрлийн баримтгүйгээр дараах ажлуудыг эхлүүлсэн байна: Хүүхдийн тоглоомын талбай (шилжих) — Чингисийн төгөл ХХК, 460,800 мянган төгрөг Худаг гаргах /2 ш цооног/ — Бодь Хараа ХХК, 20,000 мянган төгрөг Хүүхдийн тоглоомын талбай (шилжих) — Хүрэл соёмбо ХХК, 219,799.73 мянган төгрөг Цамхагт гэрэлтүүлгийн тоог нэмэгдүүлэх — Хүрэл соёмбо ХХК, 39,580 мянган төгрөг Худаг шинээр гаргах — Бимм ХХК (2025), 60,000.0 мянган төгрөг Нийт 800,179.80 мянган төгрөг-ийн төсөвт өртөгтэй барилга, байгууламжийн ажлыг эхлүүлэх зөвшөөрлийн баримтгүйгээр хэрэгжүүлсэн байна.
Шалгуур, эрх зүйн үндэслэл	Барилгын тухай хуулийн 4 дүгээр зүйлд 4.1.15-д "барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл /цаашид "барилгын ажлын зөвшөөрөл" гэх/ гэж энэ хуульд заасны дагуу барилгын ажлыг гүйцэтгэхийг зөвшөөрч, эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэрийг 25 дугаар зүйлийн 25.4-д "Энэ хуулийн 25.2, 25.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгээгүй бол барилгын ажлын зөвшөөрөл олгохыг хориглоно"
Асуудлын үндсэн шалтгаан	Захиалагчийн зүгээс гүйцэтгэгч байгууллагуудын зөвшөөрлийн бичиг баримтад тавих хяналт сул байгаатай холбоотой.
Нөлөөлөл ба үр дагавар	Хууль бус үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлж, төслийн гүйцэтгэл удаашрах, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах эрсдэл үүснэ.
Зөвлөмж	2026 онд ОНХО, ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлэх барилга байгууламжийн ажил эхлүүлэх зөвшөөрлийг бүрэн авсан байх.

Илэрсэн асуудал 4.10	Төсөвт өртөг нь нэг зуун сая төгрөгөөс дээш төсөл, арга хэмжээний хувьд тендерийн баримт бичигт заасан 15,592.6 мянган төгрөгийн гүйцэтгэлийн баталгааг захиалагчид ирүүлээгүй байхад 2 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээ байгуулсан, 8 төсөл арга хэмжээний 30,268.9 мянган төгрөгийн чанарын баталгааг гаргуулаагүй, нийт 45,861.5 мянган төгрөгийн зөрчил байна
Асуудлын ангилал	Нөлөө их

Бодит байдал	<p>Гүйцэтгэлийн баталгааг гаргуулалгүй:</p> <ul style="list-style-type: none"> • Халаалтын төвд уурын зуух шинээр худалдаж авах төсөл арга хэмжээнд гүйцэтгэгчээр шалгарсан Гом илч ХХК-тай 299,952.3 мянган төгрөгийн гэрээ байгуулахдаа үнийн дүнгийн 3 хувь болох 8,998.6 мянган төгрөг, • Хүүхдийн тоглоомын талбай төсөл арга хэмжээнд гүйцэтгэгчээр шалгарсан Хүрэл соёмбо ХХК-тай 219,799.7 мянган төгрөгийн гэрээ байгуулахдаа үнийн дүнгийн 3 хувь болох 6,594.0 мянган төгрөг, <p>Чанарын баталгаагүй:</p> <ul style="list-style-type: none"> • Хүүхдийн тоглоомын талбай 219,800.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний гүйцэтгэгч Хүрэл соёмбо ХХК-аас чанарын баталгаа 5 хувь болох 10,990.0 мянган төгрөг, • Үер усны аюулаас сэргийлэх /Аврах завь мотор багаж хэрэгсэл худалдаж авах/ 35,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний гүйцэтгэгч Нанопланет ХХК-аас чанарын баталгаа 5 хувь болох 1,750.0 мянган төгрөг, • Зохиомол хээлтүүлэг хийх багаж эхо аппарат худалдаж авах 45,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний гүйцэтгэгч Атар ирээдүй ХХК-аас чанарын баталгаа 5 хувь болох 2,250.0 мянган төгрөг, • Худаг шинээр гаргах 60,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний гүйцэтгэгч Атар ирээдүй ХХК-аас чанарын баталгаа 5 хувь болох 3,000.0 мянган төгрөг, • Хонь хяргах төхөөрөмжийг цахилгааны эх үүсвэртэй худалдаж авах 60,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний гүйцэтгэгч Атар ирээдүй ХХК-аас чанарын баталгаа 5 хувь болох 3,000.0 мянган төгрөг, • Өтөг бууц цэвэрлэх бага оврын ковш худалдаж авах 60,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний гүйцэтгэгч Атар ирээдүй ХХК-аас чанарын баталгаа 5 хувь болох 3,000.0 мянган төгрөг, • Цамхагт гэрэлтүүлгийн 45,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний гүйцэтгэгч Хүрэл соёмбо ХХК-аас чанарын баталгаа 5 хувь болох 1,979.0 мянган төгрөг, • Хогны машин худалдаж авах 90,000.0 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээний гүйцэтгэгч ЭМНМ ХХК-аас чанарын баталгаа 5 хувь болох 4,300.0 мянган төгрөг,
Шалгуур, эрх зүйн үндэслэл	<p>Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулийн 42 дугаар зүйлийн 42.1-д "Тендер шалгаруулалтын төсөвт өртөг 100 сая төгрөгөөс дээш бол гэрээний үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор гүйцэтгэлийн баталгаа шаардана", 42.5-д "Бараа, ажил, үйлчилгээний чанарын баталгаа болон зүгшрүүлэх, тохируулах хугацаанд гүйцэтгэгчийн хүлээсэн үүргийн биелэлтийг баталгаажуулах зорилгоор захиалагч худалдан авах гэрээний үнийн дүнгийн 5-10 хувийг барьцаалах нөхцөлийг тендер шалгаруулалтын баримт бичигт тусгаж болно". Сангийн сайдын 2023 оны А/252 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Худалдан авах ажиллагаанд баталгаа гаргах, орлого болгох журам"-ын 3.1 дэх "Хуулийн 42.1-д зааснаас дээш төсөвт өртөгтэй тендер шалгаруулалтад гэрээ байгуулах эрх авсан оролцогч тендер шалгаруулалтын баримт бичигт зааснаас багагүй үнийн дүнтэй гүйцэтгэлийн баталгааг захиалагчид хүргүүлнэ"</p>
Асуудлын үндсэн шалтгаан	<p>Гэрээ байгуулахдаа баталгааны шаардлагыг хэрэгжүүлэх урьдчилсан хяналтын механизм хангалтгүй байгаатай холбоотой.</p>
Нөлөөлөл ба үр дагавар	<p>Гүйцэтгэгч ажлаа буруу хийх болон хариуцлага тооцох хуулийн үндэслэл алдагдаж, ТЕЗ санхүүгийн хохирол амсах эрсдэлтэй.</p>

Албан шаардлага	2026 онд тендер шалгаруулалтын үр дүнд байгуулсан гэрээний хэрэгжилтийг баталгаажуулах зорилгоор хууль болон тендерийн баримт бичигт заасан хэмжээний гүйцэтгэлийн болон чанарын баталгааг бүрэн гаргуулж ажиллах
------------------------	---

ХОРШООГ ХӨГЖҮҮЛЭХ САН

Илэрсэн асуудал 4.11	Хоршоог хөгжүүлэх сангийн хяналт шалгалт хийгдээгүй, олон нийтэд тайлагнаагүй байна
Асуудлын ангилал	Нөлөө дунд
Бодит байдал	2024–2025 онд дараах зөрчил илэрсэн байна: Зээлийн эргэн төлөлт зохистой харьцааны 30%-ийн шаардлага хангагдаагүй (2024: 17.1%, 2025: 21.7%) Сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийгдээгүй (2024, 2025 хоёр жилд) Олон нийтэд сангийн үйл ажиллагааг тайлагнаагүй (2024, 2025 хоёр жилд) 2 хоршооны зээлийн хувийн хэрэгт хоршооны хөгжлийн төлөвлөгөө (журмын 6.10.10) байхгүй 2025 онд батлагдсан 202,920,600 ₮-ийн 19.7% буюу 40,000,000 ₮ л зарцуулагдсан
Шалгуур, эрх зүйн үндэслэл	Хоршоог хөгжүүлэх сангийн журмын 7.1-д нийт хөрөнгийн 30%-иас доошгүй хувийг эргэн төлсөн байх; шалгуур №3-т жилд 2-оос доошгүй удаа хяналт хийх; шалгуур №4-т жилд нэгээс дээш удаа олон нийтэд тайлагнах шаардлагыг тогтоосон. Журмын 7.4.2, 7.4.3, 3.4.6, 7.10-д хяналт, тайлагналын үүргийг заасан.
Асуудлын үндсэн шалтгаан	Хяналтын зөвлөл байгуулагдаагүй бөгөөд хариуцсан этгээдийн үүрэг хариуцлага тодорхойгүй байгаатай холбоотой.
Нөлөөлөл ба үр дагавар	Сангийн хөрөнгийн ашиглалт хяналтгүй болж зохистой харьцааны шаардлага хангагдахгүй, иргэдийн мэдээлэл авах эрх зөрчигдөнө.
Зөвлөмж	2026 онд хоршоо хөгжүүлэх сангийн үйл ажиллагаанд тогтмол хяналт шалгалт хийж, хөрөнгийн зарцуулалт, зээлийн эргэн төлөлт, үр дүнгийн талаар олон нийтэд ил тод тайлагнаж ажиллах.

4. ИЛРҮҮЛСЭН ЗӨРЧЛИЙН ШИЙДВЭРЛЭЛТ

Сэлэнгэ аймгийн Баянгол сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитаар засаглал, дотоод хяналт ба эрсдэлийн удирдлага, төсөв, санхүүгийн үйл ажиллагаа, орон нутгийн хөгжлийн сан (онхс) ба хоршоог хөгжүүлэх сангийн хөрөнгийн хэрэгжилттэй холбоотой нийт **4,281,107.14** мянган төгрөгийн 12 зөрчил илэрснээс санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн зөрчлийг таслан зогсоох 3,074,158.3 мянган төгрөгийн 3 албан шаардлага, 1,206,948.84 мянган төгрөгийн 8 зөрчлийг цаашид давтан гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэхээр тус тус шийдвэрлэв.

5. ДҮГНЭЛТ

Баянгол сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024-2025 оны үйл ажиллагаанд хийсэн дотоод аудитаар дараах үндсэн дүгнэлтэд хүрлээ.

Бодлогын хэрэгжилтийн үнэлгээ: ХЖТ болон МУЗГҮАХ-ийн нийт 434 арга хэмжээний 58.3% (253) зорилтот түвшинд хүрч чадаагүй; 30.2% (131) нь огт

хэрэгжилгүй (0–29%) байна. 2025 оны нийт үнэлгээ 69.43% болж өмнөх оноос 14.6 хувиар буурсан нь засаглал, хяналт-шинжилгээний тогтолцоо бүрэн төлөвшөөгүйг илтгэнэ.

Орлого, зарлагын гүйцэтгэл: 2024 онд нийт орлого 141.1%, 2025 онд 117.1% биелсэн боловч малын татвар, байгалийн нөөцийн төлбөр, түгээмэл ашигт малтмалын төлбөр гэх зарим эх үүсвэр 30–54% хооронд хэлбэлзэж, төлөвлөлт бодит нөхцөлтэй нийцээгүй байна. 2025 оны нийт зарлагын гүйцэтгэл 73.1%; тоног төхөөрөмжийн зардалд 157,808.2 мянган төгрөг нь барилга байгууламжийн шинж чанартай ажлыг буруу ангиллаар гаргасан зөрчил илэрлээ.

Худалдан авах ажиллагаа, ОНХС: Иргэдийн саналгүй, зураг төсвийг урьдчилж хийлгүйгээр ИТХ-аар төсөв батлуулсан 2,870,488.6 мянган төгрөгийн 8 төсөл хэрэгжүүлсэн; барилгын зөвшөөрөлгүй 800,179.8 мянган төгрөгийн 5 ажил эхэлсэн; гүйцэтгэл болон чанарын баталгааг 45,861.5 мянган төгрөгөөр дутуу гаргуулсан зэрэг хууль, журмын зөрчлүүд нийтлэг байна.

Иймд Баянгол сумын ЗДТГ-ын үйл ажиллагааг **“Сайжруулах шаардлагатай”** гэсэн дүгнэлтийг өгч байна.

Дүгнэлтийн төрөл	Дүгнэлтийн тайлбар
Сайжруулах шаардлагатай	Байгууллагын засаглал, эрсдэлийн удирдлага, болон дотоод хяналтын үйл явцын төлөвшил нь давтамжтай буюу 2-р түвшин"-д байна гэж үзсэн. Аудитаар илэрсэн асуудлуудын 21-79 хувь хүртэл нь “Нөлөө ихтэй” гэж үзлээ.

6.ЗӨВЛӨМЖ

Сумын Засаг даргад

1. Бодлогын баримт бичиг, хөгжлийн жилийн төлөвлөгөөг боловсруулахдаа сумын бүрэн эрх, чиг үүрэгтэй нийцүүлж, хэрэгжүүлэх боломжтой арга хэмжээг тусган, тайлагналын чанар, үр дүнгийн үнэлгээг сайжруулах.
2. Гүйцэтгэл хангалтгүй, санхүүжилтийн эх үүсвэр тодорхойгүй арга хэмжээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж, хөрөнгө оруулалтын ажлын төлөвлөлт, хэрэгжилтийн уялдаа холбоог сайжруулах.
3. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын хамрагдалт, ажилгүйдэл, халдварт өвчний үзүүлэлт зэрэг хангалтгүй үнэлэгдсэн нийгэм, эдийн засгийн үзүүлэлтүүдийг сайжруулах чиглэлээр зорилтот арга хэмжээ авч хэрэгжүүлэх.
4. Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэрэгжилтийг тогтмолжуулж, илэрсэн эрсдэлийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтэд хяналт тавих.

Санхүүгийн албанд

1. Орлогын төлөвлөлтийг өмнөх жилүүдийн гүйцэтгэл, бодит суурь үзүүлэлт, хууль эрх зүйн орчны өөрчлөлтөд үндэслэн боловсруулж, төлөвлөгөөний үндэслэл, тооцооллыг баримтжуулах.

2. Малын тоо толгойн албан татвар болон бусад орлогын авлагыг бууруулах, орлого төвлөрүүлэлтийн үр нөлөөг нэмэгдүүлэх чиглэлээр хяналт, зохион байгуулалтын арга хэмжээг эрчимжүүлэх.
3. Төсвийн хөрөнгө оруулалт, тоног төхөөрөмжийн зардлын төлөвлөлт, санхүүжилтийн хэрэгжилтэд тогтмол дүн шинжилгээ хийж, төсвийн сахилга хариуцлагыг хангаж ажиллах.
4. Авлага, өглөгийн бүртгэл, тайлагналд тогтмол хяналт тавьж, хугацаа хэтэрсэн авлага барагдуулах, өглөг бууруулах арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх.
5. Төсөв, санхүүгийн мэдээлэлд тулгуурлан улирал тутам эрсдэлийн үнэлгээ хийж, орлого бүрдүүлэлт болон төсвийн гүйцэтгэлтэй холбоотой эрсдэлийг бууруулах арга хэмжээ авч ажиллах.

Худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн нарт

6. Тендер шалгаруулалт зарлахаас өмнө зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэл бүрдсэн эсэхийг заавал шалгах, дутуу баримт бичигтэй хүсэлтийг худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд оруулахгүй байх дотоод журам мөрдүүлэх.
7. Гэрээ байгуулахаас өмнө гүйцэтгэлийн баталгаа (3%) болон чанарын баталгаа (5%)-г авч хэвших, баримтжуулах; гэрээний хугацаа сунгахад давагдашгүй хүчин зүйл үүссэнийг нотлох эрх бүхий байгууллагын шийдвэр, акт, дүгнэлт болон бусад нотлох баримт бүрдүүлэх.
8. ОНХС болон МТТАТ-ын хөрөнгөөр санхүүжүүлэх бүх төсөл арга хэмжээг сум/багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлж, журмын маягтаар эрэмбэлснээс хойш ИТХ-д батлуулах.

Хоршоог хөгжүүлэх сангийн хяналтын зөвлөлд

9. Сангийн хяналтын зөвлөлийг нэн даруй байгуулж, жилд дор хаяж 2 доошгүй удаагийн хяналт шалгалт хийх хуваарь батлах; хяналтын дүнг ИТХ-ын даргад тайлагнах.
10. Зээлийн эргэн төлөлтийн идэвхийг зохион байгуулж, жилд нэгээс доошгүй удаа олон нийтэд сангийн үйл ажиллагааг тайлагнах.

ТАЙЛАН БЭЛТГЭСЭН:

ДОТООД АУДИТОР

ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА, СХШУАБ

ТАНИЛЦСАН:

БАЯНГОЛ СУМЫН ЗАСАГ ДАРГА

ЕРӨНХИЙ НЯГТЛАН БОДОГЧ

Г.ДОРЖДЭРЭМ

Т.ОДСҮРЭН

Н.ДАВААНЫМ

Г.БАЯСГАЛАН

ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

/мянган төгрөгөөр/

№	Илэрсэн асуудлын товч утга	Зөрчлийн дүн		Аудитын шийдвэр
		Тоо	Мөнгөн дүн	
1	Төсвийн хөрөнгийг зохистой удирдаагүйн улмаас тоног төхөөрөмжийн зардлыг батлагдсан төсвөөс 65.9 хувь буюу 157,808.2 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан нь зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зөв төлөвлөөгүй, санхүүгийн тайланд үнэн зөв тусгаагүй, мөн төсвийн зардлын бүлэг, арга хэмжээ хооронд зохих журмын дагуу зохицуулалт хийгээгүй байна.	1	157,808.2	Албан шаардлага
2	ОНХС-ийн хөрөнгөөр иргэдээс санал авч, эрэмбэлэгдээгүй 2024 онд 2,087,488.6 мянган төгрөгийн 6 төсөл арга хэмжээ, 2025 онд 1,080,600.0 мянган төгрөгийн 3 төсөл арга хэмжээ, нийт 3,168,088.6 мянган төгрөгийн өртөг бүхий 9 төсөл, арга хэмжээг төлөвлөсөн байна	1	2,870,488.6	Албан шаардлага
3	Төсөвт өртөг нь 100.0 сая төгрөгөөс дээш төсөл, арга хэмжээний хувьд тендерийн баримт бичигт заасан гүйцэтгэлийн баталгааг захиалагчид ирүүлээгүй байхад 2 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх гэрээ байгуулсан, 8 төсөл арга хэмжээний чанарын баталгааг гаргуулаагүй нь холбогдох журам, шаардлагыг зөрчсөн.	1	45,861.5	Албан шаардлага
4	Хөтөлбөрийн биелэлт зорилтот түвшинд хүрч чадаагүй нийт 253 арга хэмжээ (58.3%) "үр дүнгүй"	1	-	Зөвлөмж
5	Дотоод хяналтын давтамж нэмэгдсэн боловч эрсдэлийн удирдлага бүрэн төлөвшөөгүй байна	1	-	Зөвлөмж
6	Орлогын төлөвлөлт бодит нөхцөлтэй бүрэн уялдаагүй байна	1	-	Зөвлөмж
7	Малын тоо толгойн албан татварын орлогын төвлөрүүлэлт хангалтгүй байна	1	274,516.0	Зөвлөмж
8	МТТАТ-ын хөрөнгийг чиг үүрэгт хамааралгүй нохой устгах төсөл арга хэмжээг санхүүжүүлж 2024 онд 2,700.7 мянган төгрөг, 2025 онд 5,091.5 мянган төгрөг, нийт 7,792.2 мянган төгрөгийг зарцуулсан байна	1	7,792.2	Зөвлөмж
9	Байгууллагын урсгал болон хөрөнгийн зардалд тусган хэрэгжүүлэх боломжтой ЗДТГ-ын байрны цонхны засвар, цагдаагийн хэсгийн байрны засвар, спорт заалны өмнөх талбай бетондох зэрэг 124,460.8 мянган төгрөгийн төсөвт өртөгтэй, 3 төсөл арга хэмжээг төлөвлөж зарцуулсан байна.	1	124,460.8	Зөвлөмж
10	Барилга байгууламжийг ажил эхлүүлэх зөвшөөрөлгүйгээр 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлж хууль, журмын шаардлагыг зөрчсөн.	1	800,179.8	Зөвлөмж
11	Хоршоог хөгжүүлэх сангийн хяналт шалгалт хийгдээгүй, олон нийтэд тайлагнаагүй байна	1	-	Зөвлөмж
Дүн		12	4,281,107.1	